

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-32
1. “Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагаа, үндэсний хэмжээний шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтын талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох	4-29
2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	29-32

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 06-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 18 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Номин;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар.

Нэг. “Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагаа, үндэсний хэмжээний шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтын талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн яамны Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ш.Батзаяат, Харилцаа холбооны бодлого зохицуулалтын газрын дарга Д.Баясгалан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Шуудангийн зохицуулалтын газрын дарга П.Цэрэнням, мөн хорооны Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газрын дарга Д.Ариунболд, Хуулийн хэлтсийн дарга Т.Ууганбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Монгол шуудан” ХК-ийн дэд захирал Н.Хосбаяр, “Монгол инфинити шуудан” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ф.Ганбаатар, “Түгээмэл шуурхай шуудан” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баттөр, “Юбикаб экспресс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Батзориг, Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн С.Шаравдорж, Зөвлөх инженер Ж.Баатархүү, “Нямазон аудит” ХХК-ийн захирал З.Цээнээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

“Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагаа, үндэсний хэмжээний шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтын талаар “Монгол шуудан” ХК-ийн дэд захирал Н.Хосбаяр мэдээлэл хийв.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн С.Шаравдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Зөвлөх инженер Ж.Баатархүү нар төрийн бус байгууллагуудыг төлөөлж үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ч.Ундрэм, С.Цэнгүүн, Н.Наранбаатар, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад “Монгол шуудан” ХК-ийн дэд захирал Н.Хосбаяр, Харилцаа холбооны зохицуулах хорооны Шуудангийн зохицуулалтын газрын дарга П.Цэрэнням, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, “Монгол инфинити шуудан” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ф.Ганбаатар, “Юбикаб экспресс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ч.Ундрэм, Б.Пунсалмаа, С.Цэнгүүн, П.Мөнхтулга нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагаа, үндэсний хэмжээний шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтын талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ж.Золжаргал танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Золжаргал хариулж, тайлбар хийв.

Ж.Золжаргал: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар техникийн саатлын улмаас Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал “эсрэг” гарч байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Ж.Золжаргал: Дээрх батлах санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Золжаргал: Горимын санал дэмжигдсэн тул “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 42 минут үргэлжилж, 11 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр 16 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим, 14 цаг 18 минут

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Ирц бүрдсэн тул 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирц танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Анар ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар өвчтэй байна. Галбадрах гишүүн ирсэн байна. Золжаргал ирсэн байна. Мөнхсайхан ирсэн байна. Ундром гишүүн ирсэн байна. Цэнгүүн гишүүн ирсэн байна. Ингээд ирц 54,5 хувьтай бүрдсэн байна.

Хэлэлцэх асуудал та бүхэндээ танилцуулъя.

1 дүгээрт “Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагаа, үндэсний хэмжээний шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтын талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээлэл сонсох

2 дугаарт “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 2 асуудал байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу. Санал байхгүй байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

“Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагаа, үндэсний хэмжээний шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтын талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсоно.

Хуралдаанд оролцогчдын нэрсийг танилцуулъя. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од, сайдын орон тооны бус зөвлөх Тулгат, Харилцаа холбооны зохицуулах газрын дарга Баясгалан, Стратеги бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Тунгалаг, И-Монгол Академийн хэлтсийн дарга Батмандах нар ирсэн байна.

Үндэсний Аудитын газраас Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Тэлмүүн, “Нямазон аудит” ХХК-ийн захирал Цээнээ гэсэн бүрэлдэхүүнтэй ирсэн байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Чинзориг, Шуудангийн зохицуулалтын газрын дарга Цэрэнням, Зах зээл үнэ тарифын зохицуулалтын газрын дарга Ариунболд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Цэнгэл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Нарангэрэл.

“Монгол шуудан” компаниас дэд захирал Хосбаяр ирсэн байна. Хосбаяр хаана байна. Төрийн бус байгууллагуудын төлөөлөл “Монгол инфинити шуудан” компанийн гүйцэтгэх захирал Ганбаатар, “Түгээмэл шуурхай шуудан” компанийн захирал Баттөр, “Юбикаб экспресс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Батзориг, Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн Шаравдорж, зөвлөх инженер Баатархүү. Ингээд салбарын төлөөлөл болгож бас компани нь болоод төрийн бусын хүмүүсийг урьсан байгаа. Ингээд Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од танилцуулга хийнэ.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга болон “Монгол шуудан” компанийн дэд захирал нар хамтарсан илтгэл танилцуулна.

Инновац цахим бодлогын байнгын хорооноос “Монгол шуудан” компанийн үйл ажиллагаатай танилцсан. Мөн энэ салбарт ажилладаг аж ахуйн нэгжүүд, холбоод хүмүүсээс санал хүсэлтүүд албан бичгээр хүлээж авсан. Тэгэхээр энэ ажлын хүрээнд улс орон даяар шуудангийн хүртээмжийг сайжруулах зайлшгүй шаардлага нөхцөл байдал бол үүссэн байна гэж үзээд, энэхүү арга хэмжээг зохион байгуулж байгаа. Хосбаяр дарга танилцуулна. 2 номер.

Н.Хосбаяр: Эрхэм хүндэт байнгын хорооны дарга болон гишүүд та бүхэнд хүрэлцэн ирсэн төлөөлөгч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Хосбаяр гэдэг. Монгол шуудан компанийн дэд захирал ажилтай хүн байна.

Монгол шуудан компанийн өнөөгийн нөхцөл байдлын талаар та бүхэнд танилцуулга хүргэе.

Юуны өмнө “Монгол шуудан” компанийн эрх зүйн статус болон ямар үүрэг рольтой компани бэ гэдэг талаар товчхон танилцуулга өгье.

Монгол Улс 1961 онд НҮБ-д элссэнээр НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудад гишүүнээр элссэн. Тэгээд Дэлхийн шуудан холбооны байгууллага гээд НҮБ-ын төрөлжсөн байгууллага байгаа. Энэ бол Засгийн газар хоорондын байгууллага. Монгол Улсын Засгийн газар гишүүнчлэлтэй 1963 онд болсон. Ингэснээрээ Монгол Улсын иргэдийг дотоод болон олон улсад шуудан харилцаа холбооны үйлчилгээ авах тэр эрхийг нь хангах ийм үүрэг хүлээж байгаа. Тэр үүргийг хүлээлгээд “Монгол шуудан” ХК-ийг Дэлхийн шуудан холбооны томилогдсон оператораар томилон ажиллуулж байгаа. Ингэснээрээ “Монгол Шуудан” компани Засгийн газрын нэрийн өмнөөс Дэлхийн шуудан холбооны байгууллагад томилогдоод, иргэддээ дэлхий нийттэй болон дотоодод шуудан, харилцаа холбооны үйлчилгээ авах тэр эрхийг нь хангах хүрээнд ажилладаг ийм газар байна.

2016 он хүртэл бол төрийн өмчит компанийн хэлбэртэй явж ирсэн. 2016 онд Улсын Их Хурал болон Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу төрийн өмчийг олон нийтэд нээлттэй, хяналттай болгох тэр бодлогын хүрээнд 34 хувийг нь Хөрөнгийн биржээр дамжуулаад олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгосон.

Ингээд 2016 оноос хойшоо төрийн өмчийн оролцоотой, нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй бол явж байна. Дээрх хүрээнд бол Монгол Улсын өнөөгийн байдлаар шуудангийн нийт солилцооны 80 орчим хувийг бол хийж байгаа. Мөн

үндэсний аюулгүй байдал болон онцгой байдлын үед ашигладаг ийм биет сүлжээ дэд бүтэц гэж бол үздэг.

Шуудангийн үйл ажиллагааг ер нь бол салбар нэгж болон хаягт эзнээс хүлээн аваад, хүргэж гардуулахад хүний хүч болон дэд бүтэц шаардлагатай байдаг. Тэр хүрээндээ өнөөдөр бол Монгол Шуудан компани Монгол Улсын өнцөг булан бүрд 375 салбар нэгжээрээ 1100 ажилтантай, 210 гаруй тээврийн хэрэгсэлтэйгээр дээрх үйл ажиллагааг явуулж байна. Жилдээ ойролцоогоор 2,5 сая шуудан илгээмжийг хэрэглэгчдэд хүргэж үйлчилж байн.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд компанийн эдийн засгийн үзүүлэлтийг та бүхэнд товчхон танилцуулж байна. 2014 онд бол 10,9 тэрбум төгрөгийн борлуулалттай байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар компанийн нийт борлуулалт 23,6 тэрбумд хүрсэн байна. Өнгөрсөн хугацаанд компани 2016 онд нээлттэй хувьцаат компани болсноосоо хойш өнөөдрийг хүртэл ойролцоогоор 2,8 тэрбум төгрөгийн ноогдол ашгийг хувьцаа эзэмшигчдээ тараасан байна. Жил болгон компани ноогдол ашиг бол тарааж явж байгаа.

Компани орон даяар салбар нэгжийн үйл ажиллагааг авч явахад ерөнхийдөө орон нутгийн салбарт алслагдсан байдлаас шалтгаалаад, зах зээлийн багтаамжаас шалтгаалаад орон нутгийн хэсэг дээрээ ер нь бол алдагдалтай ажилладаг. Өнгөрсөн хугацаанд бол жилд дунджаар 1,5-2 тэрбум төгрөгийн алдагдлыг орон нутгийн салбар, нэгжийн үйл ажиллагааг авч явахад алдагдал үүрч байгаа. Гэхдээ энэ алдагдлыг компани өөрийнхөө санхүүгийн эх үүсвэрээрээ нөхөөд явж байгаа. Улсаас болон төрөөс, төсвөөс ямар нэгэн санхүүгийн тусламж дэмжлэг авдаггүй байгаа.

Дэлхийн шуудан холбоо буюу Засгийн газар хоорондын байгууллагад Засгийн газраас томилогдсон Үндэсний Шуудангийн операторууд бол хоорондоо шуудан солилцож ажилладаг. Энэ хүрээндээ дэлхийн 192 улсын төрийн гэж хэлж болох шуудангийн байгууллагуудын хооронд нь энэ хөгжлийн түвшнээр нь ангилж байгаа. 1-10 оноогоор дүгнэдэг. “Монгол шуудан” Компани бол дэлхийн 192 орны шуудангийн байгууллага дунд 89 дүгээр байранд бол явж байна.

Дэлхийн шуудангийн байгууллагууд бол н дэлхий даяар тархсан өргөн салбар нэгжтэй байдаг учраас ер нь бол салбар нэгжээрээ дамжуулаад банк санхүүгийн үйлчилгээ үзүүлэх нь бол түгээмэл. Тийм учраас дэлхийн шуудангийн байгууллагууд дотроо санхүүгийн үйлчилгээ, шуудан хүргэлтийн үйлчилгээ, логистик, ачаа тээврийн үйлчилгээ гэдэг үндсэн ийм бизнесийн төрөлжилттэй байдаг.

Монгол Улсын хувьд бол санхүүгийн үйлчилгээ бол үзүүлдэггүй. Учир нь холбогдох бусад хууль тогтоомжоор банк санхүүгийн үйлчилгээ үзүүлэх нь бол хязгаарлагдмал байгаа. Дэлхийн 192 улсын шуудангийн байгууллагаас 160 гаруй нь бол санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгаа.

Төрөлжилтийг нь аваад үзэх юм бол бизнес бол төрөлжиж байгаа. Уламжлалт шуудан буюу энэ бичиг, захидал, цаасан харилцаа шуудангийн хэмжээ бол жил ирэх тусам цахимжилттай холбоотойгоор буурч байгаа ураас нөгөө талдаа энэ компанийн орлогыг бизнесийг хэрхэн төрөлжүүлэх вэ гэдэг нь сорилт болж байгаа. Энэ хүрээнд бол логистик, ачаа тээврийн үйлчилгээ, цахим

худалдааны илгээмж барааг хүргэх үйлчилгээ дээр илүү төвлөрөх шаардлагатай. Энэ нь бол бичиг цаас хүргэдэг дэд бүтцээс өөр дэд бүтэц рүү шилжих шаардлагатайг бол харуулж байгаа.

Компани бол дунд хугацааны болон богино хугацааны төлөвлөгөө гаргаад бол ажиллаж байгаа. Энэ хугацаанд 2025 онд илүү цахим шилжилт рүү төвлөрөх, датад суурилсан бизнесийн оновчлол хийх, хүчин чадлаа бол дээрх логистик ачаа тээврийн бизнес, цахим худалдааны хүргэлтэд илүү чиглүүлсэн дэд бүтцийн шинэчлэлт хийх ийм төлөвлөгөө гарган ажиллаж байгаа.

Энэ дээр нэмж хэлэхэд ялангуяа компани бизнесийнхээ төрөлжилтийг илүү цахим худалдааны хүргэлт рүү төвлөрүүлэн ажиллаж байгаа. Ингэснээрээ бол хот, хөдөөгийн иргэд бараа бүтээгдэхүүнийг дотоодын болон олон улсын үйлдвэрлэгчээс шууд ямар нэгэн өртөг зардал хямдаар хүлээн авах тэр боломж нөхцөл бол бүрдэнэ.

Цаашид компани дунд хугацааны стратегийн хувьд бол төрийн цахим үйлчилгээг хүргэх үндсэн дэд бүтэц байх зорилго тавин ажиллаж байгаа. Ингэснээрээ хот, хөдөөгийн иргэд төрийн үйлчилгээг цахимаар авахад түүнийг нь хүргэж өгдөг энэ биет сүлжээ, дэд бүтэц байх ийм үндсэн стратегитай явж байна.

2 дугаарт нь цахим худалдааны хүргэлтийг дотоодын иргэдэд хямд бага өртгөөр хүргэх ийм үндсэн цогц үйлчилгээ үзүүлэгч болох зорилтыг тавин ажиллаж байна.

Дараагийн 3 дахь зорилт нь бол орон даяар шуудан логистикийн нэгдсэн сүлжээг бий болгох. Цаашлаад бүс нутгийн хил дамнасан цахим худалдааны тээврийг Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжуулан тээвэрлэх ийм тээвэрлэгч болох ийм зорилготойгоор үндсэн 4 стратеги тавин ажиллаж байгаа. Ингэсний хүрээнд компанийн нийгэм, эдийн засгийн бөгөөд компанийн үр өгөөж бол 2,2 дахин өсөх ийм боломжтой гэж компани бол төлөвлөгөө гарган ажиллаж байгаа.

Компанийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн хувьд бол орон нутгийн жижиглэн худалдааны шуудан тээврийн хүргэлтийн хурдыг дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлснээрээ 5 дахин нэмэгдэх боломжтой. Шуудангийн үйлчилгээ ялангуяа энэ орчин үеийн хотын амьдралд бол хүргэлтийн үйлчилгээ гэдэг бол нэг шинэ соёл болж байгаа. Ялангуяа замын ачааллыг бууруулахад бол асар эерэг нөлөөтэй. Тийм агуулгаараа шуудан хүргэлтийн үйлчилгээ бол хөгжсөнөөрөө Улаанбаатар хотын замын ачаалал бол 10 хувиар буурах боломжтой гэсэн тоон судалгаа бол гарч байгаа.

Цаашлаад төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын цахим үйлчилгээг сумын түвшинд хамгийн бага зардлаар хүргэх ийм үндсэн сүлжээ байх боломжтой. Цаашлаад орон нутгийн иргэдэд хүргэх мөн санхүүгийн үйлчилгээг өртөг багатайгаар хүргэх ийм дэд бүтцийг бол байгуулна гэж төлөвлөж байна.

Цаашлаад Орос, Хятад 2 улсын хооронд болон Европ болон Азийн хооронд дамжин өнгөрөх Транзит тээврийг хэрэгжүүлэгч ийм байгууллага болгон үйлчилгээг бол өргөжүүлэхээр ингээд ажиллаж байна. Мөн хот, хөдөөгийн бараа бүтээгдэхүүний үнийн ялгааг ойртуулахад энэ дэд бүтцийн үүрэг ач холбогдол бол чухал юм.

Дээрх бодлогын хүрээнд компанийг хэрэгжүүлэхэд мэдээж хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн хөрөнгө оруулалт болон бусад цаашдын стратегийг бол гаргах, бодлогыг тодорхой болгох ёстой. Яг өнөөдрийн байдлаар компани олон нийтэд нээлттэй ХК гэдэг агуулгаараа 100 хувь төрийн өмчит компани биш, нөгөө талаараа хувийн давамгайл оролцоотой хувийн хэвшлийн компани биш. Ингэснээрээ бол энэ 2 бодлогын дунд ер нь бол орхигдож байгаа тал байгаа. Хэн нь хөрөнгө оруулах вэ, хэн нь цаашдаа энэ компанийн дэд бүтцийг сайжруулахад хөрөнгө оруулах вэ гэдэг энэ бодлого бол орхигдож байгаа гэж үзэж байгаа.

2 дугаарт зах зээлийн нөхцөл байдал болон салбарын зохицуулалтын мэдээллийг та бүхэнд товчхон хүргэе.

Шуудангийн салбар бол ойролцоогоор 60 орчим тэрбум төгрөгийн зах зээл байгаа. Энэ 2024 оны тоогоор. Нийтдээ 125 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Ер нь бол харьцангуй бодлого бол чөлөөтэй ийм үйл ажиллагаа явуулж байгаа. Тэр агуулгаараа бол илүү чөлөөт өрсөлдөөнд суурилсан харьцангуй либерал салбар гэж хэлж болно.

Цаашлаад төрийн бодлогын хүрээнд Алсын хараа 2050, Хөдөөгийн сэргэлт гэх мэт бодлогын хүрээнд орон нутагт бол амьдрах иргэдийн таатай орчныг бүрдүүлэх, хотын төвлөрлийг задлах энэ бодлого бол мэдээж төрөөс хэрэгжээд явж байна. Энэ бодлогын хүрээнд шуудангийн найдвартай, хүртээмжтэй, чанартай ийм дэд бүтцийг байгуулах бол шаардлагатай. Энэ хүрээнд шуудан компани бол үндсэн дэд бүтцийг хэрэгжүүлэх ийм боломжтой гэж харж байгаа.

Цаашлаад яг өнөөдөр компанийн хувьд бол тулгамдаж байгаа эрх зүйн зохицуулалт, салбарын зохицуулалт, хөрөнгө оруулалтын хувьд аваад үзэх юм бол мэдээж түрүүний ярьсан төрөөс баримтлах бодлого бол одоогоор яг тодорхойгүй байна гэж бол үзэж байгаа.

2 дугаарт хөрөнгө оруулалтын бодлого бас тодорхойгүй байгаа. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс хэн нь о хөрөнгө оруулах вэ, хөрөнгө оруулалтыг хэрхэн хийх вэ гэдэг бодлого бол тодорхойгүй байна. Тийм учраас энийг тодорхой болгох зайлшгүй шаардлагатай.

Цаашлаад үндсэн сүлжээний тогтвортой, тасралтгүй, найдвартай байдлыг хангаж ажиллахад бүх шатын хуулийн зүйл заалтаар бол бүх шатын Засаг дарга нар, орон нутагт бол дэмжлэг үзүүлэх ийм хуулийн зохицуулалттай байдаг. Гэвч энэ хуулийн хэрэгжилт бол хангалтгүй байгаа. Цаашлаад зах зээлийн хувьд бол мэдээж зохистой өрсөлдөөний орчин, хөрөнгө оруулсан компаниудад хөрөнгө оруулалтыг нь хэрхэн хамгаалах вэ гэдэг бодлого бол бас байх нь зүйтэй гэж бол харж байгаа.

Ингээд цаашлаад аваад үзэх юм бол нийтийн зориулалттай дэд бүтэц бол дэд бүтэц эзэмшигч компани гэж энэ компанийг бол тодорхойлж болно. Тийм учраас нийтийн үйлчилгээ үзүүлж байгаа энэ нийтийн дэд бүтэц эзэмшигч энэ компанийг хууль, эрх зүйн орчныг нь Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хууль дээр бас тодорхой болгох нь зүйтэй байна гэсэн тийм саналтай байгаа.

Мөн хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгахад гол үйлчилгээ үзүүлэгч компани гэж үзэж байгаа учраас хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж зах зээлийн хурдацтай өсөлтөд хугацаа алдалгүй шийдвэрлэх шаардлагатай байна гэж одоо үзэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. “Монгол шуудан” компанийн танилцуулгыг сонслоо. Тэгээд асуулт хариулт эхлэхээсээ өмнө нэмэлт бас байр суурь сонсьё гэж бодож байна. Энд байнгын хороонд ирсэн албан бичгүүдээс хүсэлт гаргаад орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооноос Шаравдорж гуай хүсэлт ирүүлсэн байгаа. Тэгэхээр би Шаравдорж гуайд 4 минутад багтаагаад байр суурь илэрхийлнэ гэж бодож байна. Дараагаар нь бас 1 төлөөлөл сонсоод, тэгээд түүний дараа асуулт хариултын үеэр бусад хүмүүс бас хэлж болно. Алтан-Од дарга мэдээлэл өгөх үү. 4 номер.

С.Шаравдорж: Байнгын хорооны гишүүд, дарга, энд ирсэн бүх хүмүүсийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн Шаравдорж гэдэг хүн байна. Бид яагаад энэ шуудангийн асуудлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо хөндөх болсон юм бэ гэдэг талаар би ярих гэж байна. Ер нь бол зүгээр миний ярих асуудал саяын тавьсан Монгол шуудангийн тайлан, илтгэлтэй бол зарим асуудлууд нэлээн зөрүүтэй, шүүмжлэлтэй ийм асуудлууд яригдана. Тэгэхдээ энэ бол Монгол шуудангийн үйл ажиллагааг нэлд нь шүүмжилсэн буруутгасан асуудал биш. Энэ бол зөвхөн 21 аймаг, 330 сумын түвшинд шуудангийн үйл ажиллагаа доголдож, Шуудангийн тухай хуулийн хэрэгжилт нэн хангалтгүй байна. Энд төр анхаарлаа хандуулж өгөөч гэсэн ийм л асуудлаар хандаж байгаа.

Энэ асуудал яаж эхэлсэн бэ гэхээр одоогоос 5 жилийн өмнө орон нутгийн сонины эрхлэгч нар өөрөөр хэлбэл 21 аймгийн сонины эрхлэгч нар надад холбоондоо хандсан. Энэ сонин хэвлэлээ бид нар чадан ядан гаргаад байдаг, тэгтэл хүргэдэг, түгээдэг систем нь байхгүй болчихлоо. Манай сонины уншигчид захиалагчид сониноо авч чадахгүй байна, хүргэж чадахгүй байна, түгээх ямар ч боломжгүй боллоо. 1 бол сониноо бүгдээрээ нээлттэй, учир байдлаа тайлбарлаад зогсооё, 1 бол Монгол шуудангийн асуудлыг холбоо бас анхааралдаа авч цааш нь асуудлыг тавьж өгөөч гэсэн ийм асуудал гарсан юм.

Ингээд бид за сониноо юу юугүй зогсоохоо түр хүлээж байя. Монгол шуудангийн асуудлыг ярья, хөндье. Ингээд эхлээд асуудлыг хөндөхөөсөө өмнө миний хувьд өөрийн биеэр Монгол Улсын хэвтээ тэнхлэгийн өөрөөр хэлбэл баруун чиглэлийн замын дагуух 20 сумын шуудангийн газраар орж, байдалтай нь танилцсан. Тэгэхэд үнэхээр тэнд бол сумын шууданчид 1 дүгээрт цалингүй, 2 дугаарт унаагүй, 3 дугаарт суух өрөөгүй ийм болчихсон байгаа. Энэ бол аймгийн сонины эрхлэгч нар энэ бол зөвхөн таны үзсэн сумуудын хувьд биш хавтгайдаа ийм байгаа. Бүх сумууд ийм болсон. Сумын шууданч гэдэг юм байхгүй болсон. Та мэдээгүй юм уу одоо хүртэл. Ингээд асуудлыг илүү лавшруулахаар сумын шууданчийн ажил бол сумын эмч, сувилагч эсвэл дэлгүүрийн худалдагчийн лангуун дээр явагдаж байна. Яг үнэнээ хэлэхэд. Одоо энэ сумын иргэдийн ачаа бараа, бичиг, захидал зөөх энэ бүх ажил хувийн автомашины жолооч нар, таксины жолооч нарын нуруун дээр явж байна. Энд ямар ч зохицуулалт байхгүй. Үнэ тариф баримталдаг юм байхгүй. Хэрэв тэр иргэдийн явуулсан бичиг захидал, ачаа бараа

алга боллоо гэхэд хэн ч хариуцлага хүлээхээргүй ямар ч ийм зохицуулалтгүй яваад байгаа юм.

Монгол шуудан компани энийг юу гэж тайлбарлаж байна гэхээр бид гэрээт ажилтнууд болгочихсон юм. Гэрээт ажилтан гэдэг нь тэр 375 салбар нэгжтэй гээд ингээд танилцуулгад гарч байна. Эндээс 375-330-ийг нь хасах юм бол хэд үлдэх вэ. Яг бодит байдал дээр тийм олон салбар өнөөдөр амьд үйл ажиллагаа явуулахгүй байгаа. Ингээд асуудлыг бид нар сонин хэвлэлээр тавиад ч юм уу, асуудлыг тавиад явах биш Засгийн газарт хандсан. Энэ асуудалд анхаарлаа хандуулж өгөөч. Ер нь бол Шуудангийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Хөдөөгийн иргэд, сум сууринд амьдарч байгаа иргэд шуудангийн үйлчилгээг хүртэж чадахгүй байна. Үндсэн хуулиар олгогдсон энэ төрийн үйлчилгээг авах эрх нь хаагдаж байна. Энэ асуудлыг анхаарлын төвдөө оруулж өгөх байдлаар хүсэлт тавьж, Ерөнхий сайдад одоогийн Их Хурлын дарга жилийн өмнө бид нар албан бичиг хүргүүлсэн. Ингээд сонгууль болоод энэ асуудал газар аваагүй. Дараа нь Ерөнхий сайдад хандсан. Энэ оны эхээр .../минут дуусав/

Ж.Золжаргал: Шаравдорж гуай мэдээлэл өглөө. Өөр бас 2 нэр өгсөн хүн байгаа. Тэгэхдээ одоо Монгол Инфинити компани хувийн хэвшлийг төлөөлөөд Ганбаатар гуай 4 минутад мэдээлэл өгөхийг байр сууриа илэрхийлэхийг хүсье. Тэгээд дараагаар нь гишүүд асуулт асуусны дараа асуулт хариулт дээрээ нэмэлт байр сууриа илэрхийлж явъя гэсэн бодолтой байна. Ганбаатар захирал байна уу. 3 номерын микрофон нээж өгнө үү.

Ф.Ганбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Монгол Инфинити Шуудан компани нь үйл ажиллагаа явуулаад 4 жил орчим болох гэж байна. Тэгээд шуудангийн салбарт бас тодорхой хэмжээнд үүрэг роль гүйцэтгэе. Шинэ үе ирж байна, шинэ зарчим байлгая. Тэгээд хувийн миний ажил бол шуудантай холбоотой 24, 25 жил ажиллаж байгаа хүн байгаа юм. Тэгээд бас тодорхой хэдэн санаанууд хэлчихье гэж бодож байна.

1 дүгээрт шуудангийн салбар өөрөө өнөөдөр тодорхой тоглоомын дүрэмгүй ирчихлээ. Өөрөөр хэлбэл бодлогын баримт бичиг гэдэг юм харилцаа холбооны салбар дотор шуудангийн салбарт маань алга. Хувь яаж ажиллах гэж байгаа юм, төр төлөөлж байгаа үндсэн сүлжээ эзэмшигч гэх байгууллага яаж ажиллах гэж байгаа юм гэдэг юм бол тодорхойгүй байна. Тийм учраас энийг маш тодорхой болгож байж цаашаа явахгүй бол үндсэндээ мухардмал байдалд орчих гээд байна гэдэг ийм зүйлийг хэлэх гэсэн юм.

2 дугаарт бол Шуудангийн тухай хууль маань 9 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон. Хамгийн сүүлийнх нь 2019 онд орсон. Тодорхой зүйлүүд орсон нэртэй. Энэ маань амьдралд хэрэгжихгүй байна. Нөгөө талаасаа нийгмийн шаардлага хангахаа байчихлаа. Тийм учраас шинээр дээл оёхгүй бол одоо байгаа дээл маань цоорсоор байгаад дуусчихлаа гэж. Тийм учраас шийдвэр гаргагч та бүхэн маань энэ 2 асуудлыг онцгой анхаарч өгөөч гэж 1 дүгээр асуудал байгаа юм.

2 дугаарт Харилцаа холбооны зохицуулах хорооноос 140 гаруй аж ахуйн нэгжид шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Үүнээс 100 гаруй нь хамгийн олон тоотой нь 100 гаруй нь тодорхой орнуудаас бүр тодорхой дистринейшнээс карго эрхэлдэг компаниудад л зөвшөөрөл өгсөн. Өөрөөр хэлбэл 30 гаруй компани л энэ дотоодын бөгөөд гадаадын улс дотор зах зээл дээр тоглож

байгаа. Тийм учраас нөгөө бенз ба бусад гэдэг шиг Монгол шуудан ба бусад гэдэг ийм ойлголтууд төрчихсөн. Цаашдаа яаж явах гээд байгаа нь тодорхойгүй ийм байдалд хүрчхээд байна.

Тийм учраас цаашдаа энэ тусгай зөвшөөрөл олголтын асуудлыг бол нэлээн сайн харж, анхаарч ойлгохгүй бол энэ зах зээл маань өөрөө 40 тэрбумын тоо гэж явдаг. Би бол үгүй гэж харж байгаа. Энэ маань миний ярих гэж байгаа 3 дугаар сэдэвтэй холбоотой. Өөрөөр хэлбэл шуудангийн бизнес бол дотоодын бөгөөд гадаадын урсгалаас шууд хамаардаг. Дотоодын урсгал гэхээр зэрэг улс дотроо явж байгаа шуудангийн хүргэлтийн тоо хэмжээ. Улаанбаатар хот дотор бол 30 мянган ширхэг илгээмж өдөртөө албан бус тоогоор хүргэгдээд байгаа юм байна гэдэг тоо байдаг. Ингээд харахаар бол 40 биш юм байна. 10-д үржих юм байна. 10 дахин юм байна. 300-400 тэрбумын зах зээл байгаа юм биш үү. Энэ дээр Монгол шуудан бөгөөд бусад нь яаж тоглох юм бэ. Нэг ийм асуудал байгаа.

4-д бол гадаад урсгал гэхээр зэрэг геополитикийн хувьд гео зүйн хувьд бол бид нар чинь их аятайхан байршилд байж байдаг. Өөрөөр хэлбэл Хятад гүрэн дэлхийг хувцаслана гэдэг уриатай. Ингээд хил дамнасан цахим худалдаа бол супер хөгжиж байна. Эрээн дээр нөгөө олон доллар чинь ирчихсэн. Ийм учраас бид нар дотоодынхоо зах зээлийг яаж хангах юм бэ. Энэ үндсэн сүлжээ эзэмшиж гэгдэж байгаа компани цаашаагаа бариад явах юм уу. Бусад улсууд орох юм уу, боломж байгаа юм уу, байхгүй юм уу. Гэтэл үүний цаад талд бол хэн нэгэн этгээд хэн нэгний хоолноос хүртэх гээгүй. Хятад гэдэг улсад далай шиг том энэ зах зээл чинь байгаад байдаг. Сая 11 сард ингээд Тэмү гэдэг урсгал орж ирлээ. Хүн болгон л мэдэж байгаа байх. Албан ёсоор Хятадаас орж ирсэн урсгал. Ингээд энэ урсгал дээр бол 3, 4 аж ахуйн нэгж тоглож байна. Өөрөөр хэлбэл зах зээл дээр байж байна. Бас л будилаантай. Тийм учраас энийг цэгцэлж өгөөч. Цаана нь дахиад pinuoduo ороод ирсэн. Яг энэ шиг ийм үйл ажиллагааг бид нарын хил залгаж байгаа .../минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмэлт мэдээллийг дараа нь ярилцана. Баярлалаа. Ингээд Ганбаатар захирал хувийн хэвшлийг төлөөлж мэдээлэл өглөө.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асуухад олон талын байр сууриас жишээ болгоод мэдээлэл өгөх нь зөв юм болов уу гэж үзсэн болохоор товчхон 2 мэдээлэл нэмж сонслоо.

Одоо асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Наранбаатар гишүүнээр тасаллаа. Чинбаатарын Анар гишүүн асуулт асууна уу.

Ч.Анар: Сайн байцгаана уу. Энэ Монгол шуудангийн танилцуулгаас 2 юман дээр жоохон санал нийлэхгүй байна. Би өөрөө энэ салбарт олон жил байсны хувьд Шуудангийн салбар либерал гээд байгаа юм. Энэ ерөөсөө либералчлал байхгүй байгаа шүү дээ. Сая тэр хүн хэн билээ. Сая сүүлд танилцуулсан хүний ярьж байгаагаар энэ хууль дээрээ заагаад өгчихсөн үндсэн сүлжээ эзэмшигч гэдэг зөвшөөрлөөр улс хоорондын тээвэр, транзит явахгүй байгаа.

2 дугаарт энэ нөгөө орон нутаг руу шуудангийн үйлчилгээг ерөөсөө Монгол шуудан бараг үндсэндээ монопол байдлаар барьчихсан. Нөгөө талдаа өртгийн хувьд бол хүндрэлтэй байгаа нь үнэн. Тэгээд бусад хувийн хэвшлийг оруулдаггүй.

Тэгээд 2 дугаар санал нийлэхгүй байгаа зүйл нь Монгол шуудан дээр 60 тэрбум гэж ярьж байна. Саяын 40 тэрбум гэж ярьж байна. Энэ бол хамаагүй том зах зээл. Энэ нь өөрөө улс хоорондын тээвэр, шуудангийн үйлчилгээ, ялангуяа Хятад, Оросын хооронд транзит бол маш том үйлчилгээ. Энэ өөрөө 2016 онд би яг өөрөө хувиараа судалгаа хийж байсны хувьд энэ зах зээлээс манайх хоцорчихсон байгаа. Бид нар ерөөсөө Хятадаас-Орос, Оросоос-Хятад руу тээвэрлэж байгаа үйлчилгээг шуудангийн салбарын зохицуулалтаар авах юм бол энэ бол маш том зах зээл байгаа байхгүй юу. Тэгээд энэ ерөөсөө орохгүй байгаа шалтгаан нь төр бизнес хийгээд байгаад байгаа байхгүй юу. Ерөөсөө 66 хувь нь төр. Монгол шуудангийн хувьчлал 2016 онд явсан байх. Тэр үед хувийн хэвшил ороод менежмент нь орж ирээд сайжирсан байх гэж найдаж байсан. Одоо энэ танилцуулгыг харахад бол өсөлттэй байгаа ч гэсэн дэлхийн жишиг трендийг харсан өсөлт байхгүй байгаад байна. Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээ, ямар санал байгаагаа танилцуулахгүй бол ийм зөрүүтэй мэдээллүүд яваад байна.

Сая танилцуулга дээр дурдаж байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос асууя. Хэрвээ үнэхээр либерал салбар болоод явж байгаа юм бол энэ 100 гаруй зөвшөөрлийн яагаад энэ 30 компани үйл ажиллагаа явуулаад байгаа юм бэ. Тэгэхээр энэ өрсөлдөөний орчин алдагдчихсан юм байгаа юм уу. Хууль, эрх зүйн орчин миний харж байгаагаар бол Шуудангийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2 дээр заасан 3.1.12 дээр заасан шуудангийн үндсэн сүлжээ гэж төрийн өмчийн оролцоотой буюу Монгол шууданг л энэ үйлчилгээнүүдийг эрхэлнэ гээд заачихсан байгаа нь энэ салбарыг л либералчлахгүй, орлогогүй байлгаад байна л гэж үзээд байгаа юм. Энэ дээр Харилцаа холбооны зохицуулах хорооны байр суурийг сонсьё.

Ж.Золжаргал: Минут нэмж явах уу. Анар гишүүний асуултад зохицуулах хороо Чинзориг дарга түрүүн хуралтай гээд гарсан. Оронд нь хэн хариулах вэ. 3 номер дээр микрофон нээж өгнө үү.

П.Цэрэнням: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Харилцаа холбооны зохицуулах хорооны Шуудангийн зохицуулалтын газрын дарга Цэрэнням. Анар гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Харилцаа холбооны зохицуулах хорооноос шуудангийн сүлжээ үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо 93 аж ахуйн нэгж эзэмшиж байгаа. 126 тусгай зөвшөөрөл байгаа. Үүнээс шуудангийн сүлжээний тусгай зөвшөөрлийг 4 хуулийн этгээд эзэмшиж байгаа. 73 аж ахуйн нэгж 93 улс хоорондын шуудангийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа. Гэхдээ тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа эдгээр бүх аж ахуйн нэгжүүд маань бүгд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа юу гэвэл үгүй. Өнөөдрийн байдлаар 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 62 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд үйл ажиллагаагаа эрхэлж явуулж байна.

Монгол шуудан компанийн тухайд бол Шуудангийн тухай хуулийн 3.1.12-оор Монгол шуудан компанийг бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч үндсэн сүлжээ эзэмшигч шуудангийн операторт бол тодорхойлж зааж өгсөн байгаа. Тийм учраас либерал гэдэг ойлголт маань бол энэ хуулийн заалтаар бол хязгаарлагдаж байгаа юм.

Ж.Золжаргал: Хариулт тодорхой байлаа. Тодруулж асууна. Анар гишүүн.

Ч.Анар: Тэгэхээр та өөрөө зохицуулагч байгууллагыг төлөөлөөд либерал биш гэдгийг энэ 3.1.12-оор хязгаарлаж байна гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа юм байна тээ.

Ж.Золжаргал: 3 номер.

П.Цэрэнням: Үндсэн сүлжээ эзэмшигч гэдэг ойлголтыг түрүүн Монгол шуудан компанийн дэд захирал Хосбаяр тайлбарлахдаа дэлхийн нэгдсэн том глобал сүлжээнд дэлхийн 192 орны сүлжээнд холбогдож байгаа. Үүгээр бол үндсэн сүлжээ эзэмшигч байдаг. Нөгөө талдаа дотоод болохоор зэрэг бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч учраас үндсэн сүлжээ эзэмшигч байгаа юм. Тийм учраас үндсэн сүлжээ эзэмшигч маань өөрөө бол дэд бүтэц хязгаарлагдмал бүс нутагт оршин буй ард иргэдэд шуудангийн өдөр тутмын үйлчилгээг энгийн үйлчилгээний жишиг үнэ тарифаар хүргэх үүргийг бол хүлээж ажилладаг ийм өвөрмөц онцлогтой ийм оператор компани байдаг.

Ж.Золжаргал: 2 дугаар микрофон дээр нэмэлт мэдээлэл өгье.

Н.Хосбаяр: Монгол шуудан компанийн дэд захирал Хосбаяр. Анар гишүүний асуултад хариулъя. Монгол шуудан компани монопол гэхээсээ илүүтэй төрийн өмнөөс иргэдэд үйлчилгээ хүргэх үүргийг хүлээж ажиллаж байгаа гэж томъёолбол зохимжтой байх. Яагаад гэвэл өнөөдөр орон нутагт бол хаана ч байсан хувийн хэвшил зах зээл бага учраас хүрэхгүй байгаа газар иргэдэд тэр үйлчилгээг хүргээд байгаа. Тэр агуулгаараа бол илүү үүрэг хүлээж ажиллаж байгаа гэж ойлговол зөв болох байх гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Ундрам гишүүн асуулт асууна.

Ч.Ундрам: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би орон нутгаас сонгогдсон гишүүний хувьд ерөнхийдөө асуулт асуумаар байна. Ер нь бол сумдад шуудангийн үйл ажиллагаа маш муу байгаа. Тэгээд та бүхний тайлангаас харуулж байна. Алдагдалтай байгааг гэдэг ийм асуудал байгаа. Тэгээд орон нутгийн иргэд бол баталгаатай эх сурвалжаас мэдээллээ авч чадахгүй байна. Энэ дэлхийн и-коммерс гээд худалдаанд оролцож чадахгүй байна. Орон нутагт одоо бас жижигхэн үйлдвэрлэгч нар байна шүү дээ. Органик хүнс, зөгийн балаа үйлдвэрлэчихдэг. Захиалга аваад шуудангаар хүргэх ямар ч ийм боломжгүй. Эргээд гадаадын том сайтуудаас худалдан авалт хийх ч боломжгүй ийм нөхцөл байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр түрүүн хувийн хэвшлийн төлөөлөл Монгол Инфинити компанийн Ганбаатар гээд захирал орон нутгаа ч гэсэн либералчлаад өгөөч. Тэгвэл бид нар ормоор байна гэсэн ийм санааг илэрхийллээ гэж ойлгож байна. Та хэд хэрвээ орон нутгийг либералчилбал сумдад хүрч ажиллаж чадах уу. Санхүүгийн хувьд, эдийн засгийн хувьд тийм боломж байгаа юу. Ашигтай ажиллаж чадах юм болов уу. Хувийн компаниуд сонирхох юм болов уу гэдэг ийм асуулт байна.

2 дугаарт түрүүн бас энэ төрийн бус байгууллагын тэргүүн Шаравдорж гуай хэлж байна л даа. Сумдын шуудан ямар ч байр савгүй болсон. Унаагүй болсон. Ажилчид нь цалин цавуу байхгүй болсон гээд ярьж байна. Тэгэхээр энэ сумд чинь энэ Монгол шуудан өмнө нь IPO хийгдэхээс өмнө ер нь ийм өөрийн эзэмшлийн байр, унаатай байсан юм уу, үгүй юу. Одоо тэгээд яг хэдэн сум нь байртай, хэдэн ажилтан энэ орон нутагт байгаад байгаа юм. Түрүүн бас энэ танилцуулга дээр

нийт Монгол Улсын шуудангийн солилцооны 80 хувийг бид нар хийж байна гэж байна. Үүний хэдэн хувь нь биш ээ, яг мөнгөн дүнгээр хэдэн хувь нь сумдад очдог юм болоо гэсэн ийм асуулт байна.

Дараагийн асуулт нь энэ IPO 2016 онд олон нийтэд нээлттэй хувьцаа зарагдаад яг хэдэн компани, аж ахуйн нэгжид энэ 34 хувь нь ямар томоохон хувьцаа эзэмшигч байна уу. Ямар ямар компани, иргэд энэ 34 хувийг эзэмшдэг юм бэ гэсэн ийм асуулт байна. Тэгээд дараа нь тодруулга авъя.

Ж.Золжаргал: 2 дугаар микрофон нээж өгье. Ундрам гишүүний асуултад хариулъя.

Н.Хосбаяр: Ундрам гишүүний асуултад хариулъя. Монгол шуудан компани дээр яг өнөөдрийн байдлаар сумын түвшинд 309 ажилтан ажиллаж байгаа. Байр савны хувьд бол Монгол шуудан компани 1960-1970 оны үед баригдсан шуудангийн барилгуудыг ашигладаг. Энэ нь одоогийн байдлаар 200 орчим сумд яг өөрийн байр талбай, тэгэхдээ ер нь ихэнх нь бол хуучирч муудсан ийм байдалтай байж байгаа.

Компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд бол нийт Хөрөнгийн бирж дээр 34 хувиа IPO хийж нээлттэй хувьцаат компани болсон. 34 хувиас 2024 оны 12 сарын байдлаар Ард санхүүгийн нэгдэл болон түүний төлөөлөл компаниуд нийтдээ 25 орчим хувийг нь эзэлж байгаа. Үлдсэн 9 хувийг нь 3380 орчим хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшиж байна.

Ж.Золжаргал: Нэмэлт хариулт өгөх үү. Хувийн хэвшлээс. Ганбаатар. 1 дүгээр микрофон нээж өгье.

Ф.Ганбаатар: Ундрам гишүүний асуултад хариулъя. Сумын түвшинд ашигтай байх юм уу, үгүй юу гэж. Одоо бол яах вэ дээ, мэдээж хэрэг Монгол инфинити шуудан буюу 1 хуулийн этгээд сумын түвшинд дангаараа байна гэж боломжгүй. Өөрөөр хэлбэл, бид нэг консорциум гэж нэрлэх юм уу.3, 4-үүлээ нийлчихсэн. Энэ улсаа баруун, зүүн, хойд, урд гэдэг шиг хуваачихсан ийм зарчмаар явахад бол нээлттэй. Энэ сэдэв бол өнөөдрийг хүртэл яригдаж байгаа сэдэв. Гагцхүү нөгөө гарц гаргалгаа нь яах гээд байгаа юм бэ. Үнэхээр энэ болох юм уу, болохгүй юм уу. Одоо энэ чинь тэгээд энэ сэдвийг хөндсөн дээр хэлэхэд орон нутаг руу гэдэг нэг ийм хүч тарамдсан юм их төвөгтэй болж байна. Тийм учраас Монгол шуудангийн зовлонг ойлгож байна. Яагаад гэвэл энэ чинь төрөөс татаас авахгүй. Өөрөөр хэлбэл хувьчлалын жилийг хүртэл төрөөс их бага хэмжээгээр ямар нэгэн байдлаар авч ирсэн. Тэр бол .../минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмэлт цаг өгье. 1 номер.

Ф.Ганбаатар: Тэгэхээр хувьчлалаас хойш энэ чинь тэгээд Монгол шуудан компанийн бас нөгөө талдаа буруу биш шүү дээ. Тэгээд хувийн компани юм уу, төрийн компани юм уу. 1 харахаар паблик листэд компани хувьцаатай байж байдаг, нөгөө талаас нь харахаар төр байгаад байдаг. Тэгсэн хэр нь ард иргэд Монгол шуудан муу байна гээд байдаг. Тийм учраас энэ бүх гарц гаргалгаануудыг цаасан дээр тодорхой буулгаж өгөхгүй бол бид чинь ингээд хоорондоо толхилцоод л нэг тийм утгагүй байдалд хүрэх гээд байна л гэж. Зүгээр яг сумын түвшинд яаж

ажиллах гээд байна гэхээр бид нар бол консорциум болоод ажиллахад бэлэн. Тэнд бол ашигтай байлгаж чадна гэж хариулах байна.

Ж.Золжаргал: Болсон уу. Нэмэлт авах юм уу. Тодруулж асууна Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Ерөнхийдөө энэ Монгол Улс чинь хотоос хөдөө рүү гэж байгаа. Тэгээд орон нутагт энэ том өргөн уудам нутгаа манайд амьдарч байгаа хүмүүсийн эрх ашиг маш чухал байдаг. Тэгээд мэдээж нөгөө талаас хувийн компаниуд бол ашигтай ажиллах ёстой. Тэгэхээр хэрвээ нийгмийн шаардлагаа яг тэнд байгаа хүмүүст тэр хэрэгцээ шаардлагыг нь хангаад өгөх юм бол консорциум болоод ажиллаж болно гэж та хэлж гэж би ойлголоо шүү дээ. Тийм ээ. Тэгээд мэдээж энэ дээр бол хууль, эрх зүйн асуудлыг нь бид нар сайжруулах зайлшгүй хэрэгтэй юм байна. Одоо бол түрүүний миний яриад байгаа энэ сумын хэрэгцээ шаардлагыг Монгол шуудан энэ ачааг нь үүрээд явж байна шүү дээ. Тэгэхээр бид нар энийг яаж хамгийн зөв болох вэ гэдэг дээр ажлын хэсэг байгуулагдаад хууль, эрх зүйн орчныг сайжруулаад ингээд ажиллах ёстой юм болов уу л гэсэн ийм л бодол санал хэлж байна.

Ж.Золжаргал: Баярлалаа. Цэнгүүн гишүүний микрофоныг нээж өгье.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Шуудангийн салбарын өнөөгийн нөхцөл байдлын тухай бид нар ярилцаж байна. Тэгэхээр энэ салбарын талаар ярихын тулд бид нар зайлшгүй цахим хүргэлт, цахим худалдаатай холбоотой энэ хүргэлтийн үйлчилгээний тэсрэлтийн талаар зайлшгүй ярих шаардлага бол гараад байгаа юм. Тэгэхээр сүүлийн жилүүдэд харахаар 50 мянга орчим онлайн бизнес эрхлэгчид байнгын үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд энэ онлайн бизнес эрхлэгчид маань бол хүргэлтийн үйлчилгээгээрээ өдөр болгон иргэддээ хүрээд явдаг. Тэгээд яг статистик судалгаагаа хараад үзэхээр өдөрт 240 орчим сая төгрөг бол эргэлдэж байна. Улаанбаатар хот дотор. Тэгээд үүнээс юу харуулж байна вэ гэхээр энэ бол асар том зах зээл байгаа юм. Энэ цаашаагаа бол өргөжин тэлэх бүрэн боломжтой. 2024 оны 11 сард гэхэд Хятадын Тэмү гээд дэлгүүр орж ирсэн байхад тэр дээр бол жишээ нь хэдхэн сарын дотор л 24 тэрбумын бараа бүтээгдэхүүнийг Монголоос захиалчихсан байгаа юм. Тэгээд эндээс юу харагдаад байна гэхээр энэ хүргэлтийн үйлчилгээтэй холбоотой энэ салбар чинь өөрөө асар их нөөц боломжтой харагдаад байна.

Сая Монгол шуудан компанийн гүйцэтгэх захирлын яриан дундаас ингэж хэлж байна. Зах зээл жижиг болохоор ерөнхийдөө бол бид нар бүрэн хүрч ажиллаж чадахгүй байна гээд хэлээд байгаа юм. Гэтэл төрийн бус байгууллагын Шаравдорж гуайн хэлж байгаагаар бол энэ орон зай дээр чинь Монгол шуудан өөрөө өрсөлдөж чадахгүй байна шүү дээ. Монгол шуудан бол 1990 хэдэн онд батлуулж байсан тэр 48 цагийн дотор илгээмжийг хаягт нь амжилттай гардуулна гэдэг тэр стандартаа бариад л асар удаан байгаа шүү дээ. Хувийн компаниуд хувийн хүргэлтийнхэн бол 12 цагийн дотор тухайн өдөрт нь яаж хүргэлтээ хийх вэ гээд маш түргэн шуурхай ажиллаж чадаж байгаа учраас орон нутагт байгаа иргэд болон Улаанбаатар хотын иргэд чинь бүгдээрээ хувийнхнаар сонгоод үйлчлүүлчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр өрсөлдөөн дээр бид нар Монгол шуудан бол ялагдаад байна гэсэн үг. Дээрээс нь өрсөлдөөн дээр ялагдаж байгаа нэг том юм бол үнэ тарифын хувьд монопол байдлаа энэ чинь хадгалаад байгаа гэдэг нь л энэ тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нь байгаад байгаа хэр нь үйл

ажиллагаа явуулахгүй энэ чинь өөрөө либералчлагдсан салбар биш байгааг нь харуулаад байна.

Тэгэхээр ер нь Монгол шуудан компанийн 66 хувь нь төрд байгаад байгааг эргэж харах хэрэгтэй болчихжээ. Бид нар ингээд Ард санхүүгийн нэгдэл авсан. Ард санхүүгийн нэгдэл 24 хувийг нь эзэмшдэг. Тэгээд 10 нь болохоороо жижиг хувьцаа эзэмшигч нар байгаа. Ингээд харахаараа нээлттэй хувьцаат компани юм шигээр хувийн компани удирдаж байгаа юм шиг харагддаг бол шийдвэр гаргагч нь бол төр хэвээрээ байгаад байгаа юм. Тэгэхээр эндээс бид нар ер нь төрийн оролцоог нь багасгаад, төр өөрөө 34 хувьтай болоод, хувийн хэвшлийн оролцоог нь нэмээд өгөх юм бол бид нар энд чинь өрсөлдөөнийг дэмжих боломж нь харагдаад байна.

Дээрээс нь бас нэг юм Цахим хөгжлийн яамнаас асуумаар байна. Энэ шуудангийн салбарын хүргэлттэй холбоотой, дээрээс нь цагдаа, онцгой, эрүүл мэндийн яаралтай үйлчилгээнд түргэн тусламжийг хүргэхийн тулд энэ хаягжилтын стандартыг мөрдүүлэх зайлшгүй шаардлага байна. Энэ дээр та бүхэн ажиллаж байна уу. Энэ хүргэлт үйлчилгээ үзүүлэхэд чинь хаягжилт чинь тодорхойгүй учраас бас хүндрэлтэй байгаад байна. Албан ёсны хаягаар хэзээ ч ярьдаггүй. Ойролцоогоор хүмүүс бол аман дадлаараа сурсан тэр хаягаараа хэлж байж хүмүүс бие биеэ хаана байгаагаа олоод байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлэх үү гэдгийг цахим .../минут дуусав/

Ж.Золжаргал: Эхлээд төрийн хувь эзэмшлийг багасгаад 34 хүртэл эсрэгээрээ багасах талаар ямар нэгэн одоо тооцоолол бодол тийм зүйл байдаг уу гээд шууд Монгол шуудан компаниас асуучихъя. Компанийн хувьд 66 хувиа 34 болох. Компанийн хувьцааны ер нь хувь эзэмшлийн байдал ямархуу байгаа вэ гэдэг мэдээлэл өгье. 2 номер.

Н.Хосбаяр: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Компани ер нь бол үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр ч тэр, олон улсын конвенцын дагуу хүлээсэн үүргийн хувьд ч тэр ер нь бол олон улстай дэлхийн 192 оронтой Засгийн газар гишүүний хувьд харилцаж байгаа. Тэрийг төлөөлөөд Монгол шуудан компани ажиллаж байгаа. Тэгэхээр хувийн давамгайд оролцоотой болсноороо яах вэ гэвэл л тэр үүрэг харилцаа бол хувийн хэвшил рүү шилжинэ гэсэн үг. Тэгэхээр 50-аас дээш байх уу, доош байх уу гэдгээсээ хамаарна гэсэн үг. Манай тендерийн тухай хуулиар ч тэр бүх харилцаа бол 50-аас дээш төрийн өмчийн оролцоотой байх юм бол тендерийн хуулиар зарладаг. Энэ нь өөрөө бизнесийнхээ процесстой бас 1 дүгээрт уялдахгүй байгаад байгаа.

2 дугаарт түрүүний хэлж байгаа тэр хүргэлтийн чанар бөгөөд үнийн хувьд бол ярилцсан. Үнийн хувьд бол Монгол шуудан компанийн үнийг нөгөө бүх нийтийн үйлчилгээний үүрэг хэрэгжүүлэгч гэдэг утгаараа тарифын дээд хязгаарыг бол Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталж байгаа. Яагаад гэвэл бүх иргэд тэр үнийг төлөх боломжтой үнэтэй байх ёстой гэдэг утгаараа. Тийм учраас Монгол шуудан компанийн үнэ бол харьцангуй хямддаа орж байгаа.

Хувийн хэвшлийн хувьд бол Монгол шуудан компани дангаараа, зөвхөн дангаараа ажиллана гэдэг тийм бодлого баримталдаггүй. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан стандартын дагуу бас харилцаа холболтын гэрээ гэдэг ойлголт бол байдаг. Ингэснээрээ Монгол Шуудан компани үндсэн сүлжээ юм бол бусад хувийн хэвшил хүрч чадахгүй байгаа газар нутагтаа үйлчилгээнийхээ

хэсэгтээ Монгол шуудангаар дамжаад хүрэх тэр харилцан холболтын гэрээ гэдэг юм байгаа. Бид нар өнөөдрийн байдлаар 14 хувийн хэвшлийн компанитай харилцан холболтын гэрээтэй. Тэгэхээр орон нутагт салбаргүй хувийн хэвшлийн компани Монгол шууданд яг адилхан баталсан стандарт үнийг нь төлөөд, орон нутагт үйлчилгээгээ хүргэдэг ийм үйлчилгээ бас явж байгаа.

Компанийн тэр хувьцааны хувьд бол 34 байх уу, 50-аас дээш байх уу гэдгийг бол Засгийн газар бөгөөд хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа тал бол хариулсан нь зөв байх гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Яамнаас саяын их тодорхой асуултад хариулахаас гадна ер нь энэ хэлэлцэж байгаа асуудлын хүрээнд шуудангийн үйлчилгээний хүртээмжийг яаж хүртээмжтэй болгох вэ. Цахим худалдааны талаар ямар бодлого барьж байгаа талаар байр суурь илэрхийлсэн нь зөв байх. Хэдэн номер дээр байна. 6 номерын микрофон нээж өгье.

М.Тулгат: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх Тулгат. Цэнгүүн гишүүний асуултад хариулъя.

Хаягжилтын асуудал бол туйлын чухал асуудал байгаа. Тэгэхээр маш зөв зүйлийг хөндлөө гэж үзэж байна. Хаягжилтын тухай хуулийн төсөл өнгөрсөн онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эхнийх нь төсөл яваад, энэ дээр бол холбогдох талуудаас саналыг нь аваад, ингээд өнгөрсөн 4 дүгээр сард хуулийн төслийн үзэл баримтлал нь батлагдсан. 3 яамны сайдын хамтарсан тушаал батлагдаад явсан байгаа. Ингээд энэ Хаягжилтын тухай хуулийн ажлын хэсэг бол ажиллаад явж байгаа. Өчигдөр бас хуралдсан. Гэхдээ яг хаяг гээд ярихад бас бид нар бас ялгаж салгаж ойлгох ёстой хэдэн зүйл байдаг.

1 дүгээрт орон зайн кодчиллын асуудал.

2 дугаарт хаягийн нэршлийн асуудал. Жишээлбэл БЗД-ийн 30 дугаар хороо гэдэг ч юм уу гудамжны нэршил.

3 дугаар асуудал нь юу вэ гэхээр тэмдэглэгээ, хаягийн самбар. Тэгээд энэ 3 ойлголтыг бас ялгаж салгаж ойлгоогүйгээс болоод энэ Хаягжилтын тухай хууль, энийг цэгцлэх асуудал маань урагшгүй яваад байдаг тал бий. Мөн энэ хаягтай холбоотой оролцогч талууд их олон байж ирсэн. Жишээлбэл Барилга, хот байгуулалтын яам, нийслэл, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, өнөөдрийг хүртэл Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам бол 3 жилийн өмнө байгуулагдсан. Тэгээд өмнөх агентлаг байсан үеэс шуудангийн кодын асуудал гээд энэ олон талууд оролцоотой байдаг өөр өөрийн бас хэрэгцээ шаардлага байдгийн улмаас энэ маань бас нэг цэгцрэхгүй яваад байсан ийм одоо дүр зураг байсан. Тэгэхээр энийг шийдье гээд талуудын оролцсон хамтарсан ажлын хэсэг явж байгаа.

Тэгээд яг энэ цаг үед бас та бүхэндээ бас хэлэх зүйл юу байна гэхээр энэ хаягийн асуудал маань одоо юу руу орж ирж байна гэхээр хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын эрин зуунд .../минут дуусав/

Ж.Золжаргал: 6 дээр нэмж цаг өгье. Цэгцлэх гээд ажлын хэсэг явж байгаа гэсэн шүү дээ. Яаж цэгцэрч байгаа, хэзээ цэгцэрч байгаа талаар нь та мэдээлэл өгөөрэй.

М.Тулгат: Тэгэхээр энэ хиймэл оюуны яг үндсэн хамгийн гол зүйл бол та бүхэн мэдэж байгаа их өгөгдөл. Тэгэхээр хаяг гэдэг маань өөрөө мастер өгөгдөл болохын хуваарь энэ маш чухал болж эхэлж байгаа юм. Тэгэхээр бид нар бол энэ шуудангийн код, хаягжилтыг бол өмнөх шигээ журмаар батлаад засаг захиргааны нэгж өөрчлөгдөнгүүт дагаж өөрчлөгдөөд байдаг ийм байдлаар явах юм бол Цэнгүүн гишүүний гаргаж тавьж байгаа энд ярьж байгаа хүмүүсийн асуудал бол шийдэгдэхгүй учраас бид нар яг орон зайн хувьд он цагийн орон зай цаг хугацааг давсан засаг захиргааны нэгжийн өөрчлөлтөд өөрчлөгддөггүй байх ийм зүйлийг эцэслэж гаргая гээд явж байгаа. Тэгээд ер нь яг хаанаас энийг нь шийдээд явах юм, хуульчлаад явах юм гэдэг энэ зүйлүүдийг нь ажлын хэсэг дээрээ бол хэлэлцээд явж байгаа. Хуулийн төсөл нь бол гарчихсан явж байгаа гэдгийг хэлье.

Ж.Золжаргал: Хуулийн төсөл гарчихсан юм байна. Олж мэдэж болох юм байна. Цэнгүүн гишүүн нэмэлт асуулт.

С.Цэнгүүн: Монгол шуудан компанийн захирлын хариулттай холбоотой бас ярих гэсэн юм. Ер нь нээлттэй хувьцаат компани болгоод төрийн хувьцааг багасгалаа гээд юу ч муудахгүй. Ер нь төр 100 хувь эзэмшилтэй байгаа компаниудын нөхцөл байдал ямар байдаг билээ. Төр 100 хувь эзэмшиж байгаа компаниуд дээр орсон аудитын тайлан ямар байдаг билээ. Энд сууж байгаа гишүүд ч бас мэдэж байгаа юм. Тэгээд өнөөдөр Монгол шуудан компанийн 34 хувь нь хувьд байгаад, тэгээд орж ирсэн аудитын тайлантай нь танилцаад үзэхээр маш деталь жижиг жижиг мөнгөн дүнтэй хүртэл тоонуудыг нь гаргаж ирж тавьсан байна л даа. Энэ Үндэсний аудитын газраас орсон аудитын компанийг нь би бол маш сайн ажилласан байна гэж хэлмээр байна. Тэгээд бүр эрчим хүчний яамны компаниуд руу ч гэсэн оруулмаар санагдаж байна. Ийм чанартайгаар аудит хэрвээ хийгддэг байх юм бол. Тэгээд энэ юуг харуулж байна гэхээр төрийн оролцоот компани байгаад хувийн хэвшил ороод ирэхээр энэ дотроо харилцан хяналтууд бий болоод, үргүй зардлуудыг чинь багасгаад .../минут дуусав/

Ж.Золжаргал: Үг хэллээ. Наранбаатар гишүүний микрофон нээж өгнө үү.

Н.Наранбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр төрийн бодлого бол бүсчилсэн хөгжлийн бодлого. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хөдөө орон нутгаа хөгжүүлэх рүү л чиглэж байгаа шүү дээ. 7 бүс болгон хуваасан. Одоо 2 бүсийнх нь зөвлөгөөнийг хийсэн. 5 сарын 12-нд говийн бүсийн зөвлөгөөнийг бол сайн Сайншанд хотод хийнэ. Тэгэхээр Монгол төрийн бодлого Засгийн газрын зорилт бол энэ бүсчилсэн хөгжил, хөдөөг хөгжүүлэх байгаа. Тэгэхээр энэ дээр олон төрлийн ажлууд хийж байгаа л даа. Нэг орхигдоод, бага яригдаж байгаа зүйл бол шуудан хүргэлтийн асуудал байгаа. Хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байгаа ялангуяа суманд ажиллаж амьдарч байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудад бол энэ шуудангийн үйлчилгээ хангалт муутай л байгаа гэж ойлгож байгаа. Саяын мэдээллээс ч гэсэн эндээс тарааж өгсөн юмыг харахад ч гэсэн алдагдалтай байдаг юм байна.

Тэгэхээр Монгол шуудан компаниас асуухад гол нь юун дээрээ байдаг юм бэ. Энэ орон нутгийн шуудан хүргэлтийн үйл ажиллагаа муу байгааг цаашдаа яаж

засаж сайжруулах ёстой юм вэ гэдэг дээр нэг товчхон санаагаа хэлэх хэрэгтэй. Хөрөнгө мөнгө, төсөв дутуу байдаг юм уу. Аль эсвэл төсвөөс зайлшгүй ийм зүйлийг хийх шаардлагатай байна. Төрөөс гэдэг зүйлүүдийг товчхон тодорхой хэлээд хэлбэл сайн байна.

Яамнаас бас асууя. Энэ шуудангийн хууль чинь батлагдаад зөндөө нэмэлт, өөрчлөлт орчихсон юм байна. Тэгээд яг үүргээ гүйцэтгэж чадаж байгаа юм уу, үгүй юм уу. Ер нь төрийн бодлого юу байх юм. Энэ шуудантай холбоотой. Та бүхэн ямар ажил хийж байгаа юм. Хуулиа шинэчлэх гэж байгаа юм уу, үгүй юу. Төрийн шуудангийн талаар баримтлах бодлого нь юу юм. Ямар ажлууд төлөвлөж байгаа юм энэ чиглэлээр холбогдох яамтай болсон шүү дээ бид нар чинь. Тэгээд яах гэж яамтай болгосон юм. Тэгээд энэ асуудлуудаа л шийдэх гэж яамтай болгосон гэж бодож байгаа шүү дээ. Харьцангуй манай улс бол бага газар нутагтай. Томоохон газар нутагтай Хятад, Америк, Канад бол энэ шуудангийн үйлчилгээ бол тэр хөдөө орон нутаг аль ч цэгтэй саадгүй л очиж байгаа шүү дээ. Тэгээд тийм болгохын тулд манай яам ямар ажлууд хийж төлөвлөж байгаа юм бэ. Улсын Их Хурлын дэмжлэг юу байх юм бэ энэ дээр гэсэн ийм 2 асуултад хариулт аваад, дараа нь тодруулъя.

Ж.Золжаргал: Эхлээд Монгол шуудан компани хариулъя. Яаж үйлчилгээгээ сайжруулж болох вэ гэдэг дээр. 2 дугаар микрофон нээж өгнө үү.

Н.Хосбаяр: Мэдээж шуудангийн бизнесийн зах зээл бол өөрчлөгдөж байгаа. Тэрийг дагаад яаж байна гэхээр компанийн дэд бүтцүүдийн шинэчлэлт хийх шаардлагатай. Өмнө нь цаас зөөдөг байсан бол одоо ачаа бараа зөөдөг ийм шуудангийн бизнесийн төрөлжилттэй болчихсон. Тэгэхээр цаас зөөхөд ашигладаг дэд бүтэц өөр. Ачаа бараа зөөхөд ашигладаг дэд бүтэц өөр. Дэд бүтцийг нь өөрчлөхийн тулд хөрөнгө оруулалт шаардлагатай. Тэгэхээр 1 бол компани юу гэдэг юм 50-аас доош, 34-өөс дээш хувийг нь төрийн эзэмшилд ороод илүү чөлөөтэй бизнесийн зарчмаар ажилладаг компани болох ёстой. 1 бол төрийн үүрэг юмаа орон нутагт бизнесийг иргэдэд үйлчлэх нь төрийн үүрэг юм гэж үзвэл 100 хувь төрдөө авах ёстой. Энэ хоёрынхоо аль нэг тал руу нь төр зайлшгүй шийдвэрээ гаргах шаардлагатай. Үүний голд нь байгаад байгаа учраас хэн тэр хувьцаа эзэмшигчийн хувьд тэр дараагийн шатын хөрөнгө оруулалтыг хийж энэ компанийн дэд бүтцийг сайжруулах вэ, технологийг нь сайжруулах вэ гэдэг нь өнөөдрийг хүртэл тодорхой бус байгаа. Асуудлаа эндээ байна гэж харж байна.

Ж.Золжаргал: Яамнаас хариулт өгнө. 5 номер.

П.Алтан-Од: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Шуудантай холбоотой өнөөдөр Байнгын хороо дээр бодлогын асуудал яригдаж байгаа. Тэгээд яам бол хууль, эрх зүй өнөөдөр 22 жил хэрэгжсэн Шуудангийн тухай хуулийнхаа хэрэгжилтийн үр дагаварт нь үнэлгээ хийсэн. Үүнтэй холбоотойгоор шуудангийн салбарын хөгжил, бодит байгаа нөхцөл байдал, шаардлага, цаашид хууль, эрх зүйн хүрээнд шинэчлэл өөрчлөлтийг авчих ийм зайлшгүй шаардлагатай байна гэдэг дүгнэлт гарсан. Ер нь яамнаас 2025, 2026 онд дамжуулж тулгамдаж байгаа асуудлыг шийдэх хүрээнд Шуудангийн тухай хуулийг бид нар энэ ондоо бол өргөн барьж амжихгүй. Ямар ч байсан ажлын хэсгүүд гарчихсан. Олон улсын туршлага, явж ирж байгаа нөхцөл байдалтайгаа бодит дүн шинжилгээ хийх гээд хуулийг

чанартай боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. 8 удаагийн өөрчлөлт орсон боловч бодит байдал дээр та бүхний харж байгаа хувийн хэвшлийн хэлж байгаа энэ дүгнэлт бол бас бодитой нөхцөл байдал байгаа гэдгийг аль аль талаасаа харж байгаа.

Монгол Улс шуудан, цахим худалдааны бодлогын баримт бичиг боловсруулах ийм зайлшгүй шаардлагатай тулгарч байгаа. 1 талаасаа цахим худалдааны асуудал, цахимжилттай холбоотойгоор шуудан, уламжлалт шуудан хүргэлтийн асуудлыг ямар байдлаар, ямар бодлогоор шийдэж ирэх вэ гэдэг асуудлыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг яаман дээр гаргасан байгаа.

Шуудангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. Хаягжилтын тухай хуультай холбоотой ажлын хэсэг Засгийн газар дээр гарсан ажлын хэсэг дээр яамнаас санал боловсруулаад, ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байгаа.

Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколыг Улсын Их Хурлаар соёрхон батлуулах төслийг боловсруулсан. Энэ хаврын чуулганаар батлуулахаар зорьж ажиллаж байна. Ази Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг мөн хувийн хэвшил, төрийн байгууллагуудыг оролцуулсан .../минут дуусав/

Ж.Золжаргал: 5 дугаар микрофонд нэмэлт цаг өгье.

П.Алтан-Од: Замын-Үүд одоо боомтод шуудан логистикийн төв байгуулах ТЭЗҮ, геополитикийн болоод энэ худалдааны олон улсын нөхцөл байдалтай уялдуулаад зайлшгүй ийм логистикийн төвийг байгуулах ёстой гэж ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавраа төрийн худалдан авах ажиллагаанд хүргүүлсэн. Энэ тендер зарлагдаж, энэ ондоо ирэх жилийн төсөв болоод ямар эх үүсвэр шийдэгдэх вэ гэдэг дээр ТЭЗҮ-ээ бид нар боловсруулж ажиллаж байна.

Цахим худалдааны хууль, эрх зүйн орчныг боловсруулах ер нь Монгол Улс худалдааны хууль, эрх зүйн орчноо шинээр бий болгох асуудал яригдвал цахим худалдааны хууль, эрх зүйн орчныг аль талдаа шийдэж явах юм бэ гэдэг асуудлыг ярих, Эдийн засаг, хөгжлийн яам дээр энэ ажлын хэсэг ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Бид нар энэ цахим худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр бас бодлогын судалгааны ажлууд хийгдэж байгаа.

Олон улсын цахим худалдааны дэд бүтцийг бий болгох чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөнүүдийг зохион байгуулах, олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтран идэвхтэй ажиллах чиглэлээр бол бодлогын чиглэлийн ажлуудыг бол яам авч хэрэгжүүлж ажиллаж байгаа. Цаашид нээлттэй компанийн асуудал нэг талаасаа явж байгаа. 2 дугаарт төрийн оролцоотой гэдэг утгаараа явж байгаа учраас энэ ер нь листэд компаниудын үйл ажиллагаа зах зээл дээр гарч байгаа хэвлэл мэдээллээр гарах гэж байгаа мэдээллүүдээрээ ч гэсэн манай салбарынхан шуудангийн салбарынхан тэр тусмаа их учиртай дуугарахгүй бол энэ листэд компанийн мэдээлэл бол олон улсдаа ч гэсэн их болгоомжтой ханддаг улс төр нь ч гэсэн болгоомжтой ханддаг учраас Их Хурлын гишүүд маань ерөнхий байдлаар асуултаа асууж байгаа. Манай салбарынхан энэ дээр бас жоохон болгоомжтой, хариултуудаа их бодлогын түвшиндээ хариулаарай та бүхэн маань.

Ж.Золжаргал: Болсон уу. Сумд ч шууд хүрэхгүй байгаа асуудлууд бол яг бодитой байна. 2 дугаарт нь төрийн хэвшил, хувийн хэвшил яавал шударга өрсөлдөж, яавал бүгдээрээ тэгш ийм боломжтой байх вэ гэдэг асуудал тавигдаад байгаа юм. Энэ бас яг бодитой. Салбар дээр нь ажилладаг хүмүүсийн ийм мэдээллүүд ирээд байна. 3 дугаарт нь цахим худалдаа, дээрээс нь олон улсын шуудан илгээмж их хөршүүдийн дунд оршдог, мөнгө хийх боломж их байгаад байдаг. Тийм болохоор ер нь цаг нь бол болчихсон. Одоо энэ бодлогын баримт бичгүүдээ эргэж нэг харах, эрх зүйн орчноо сайжруулах. Яамнаас өгсөн мэдээллийг бол сонслоо. Яамнаас бол ажиллаж байгаа юм байна. Тэгэхдээ бид нар чинь их олон жил ажиллаж байгаа шүү дээ. Тийм болохоор энэ удаагийн Их Хурлын гишүүд бас өөрсдөө санаачилгатай энэ асуудлыг бид нар гаргаж ирээд, шийдэл олох ёстой юм байна гээд өнөөдөр энэ энэ асуудлыг сонсоод, дараа нь ажлын хэсэг гаргах юм.

Би Цэрэн даргаас 1 асуулт асуучихмаар байна. Энэ юунууд цахим худалдааны хүргэлт хийж байгаа залуучуудаас бас санал, гомдлууд ирсэн. Тэгээд орон нутагт юм хүргэхээр тусгай зөвшөөрөлтэй компани байх ёстой гээд байх юм гээд. Тэгээд энэ чинь аль хэзээний цахим худалдааны эрх зүйн орчин хуультай хуульгүй ингээд амьдрал болчихсон шүү дээ. Фэйсбүүкээр явж л байгаа, хүргэж л байгаа. Тэгэхээр энийг яаж хөнгөхөн, хурдан болгох вэ. Энэ тал дээр тайлбар өгнө үү. 3 Номер.

П.Цэрэнням: Дэлхий нийтийг хамарсан цар тахлын хор нөлөө буурч багасаж, цахим худалдааны эргэлт хурдацтай нэмэгдэж байгаа нь шуудангийн салбарт бол өсөлт хөгжилтийг авчирч байгаа нь бол бодитоор мэдрэгдэж байгаа. Энэ нь бол ялангуяа БНХАУ цахим худалдааныхаа салбарт эрс шинэчлэлийн бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотой гэж үзэж болохоор байгаа. Яагаад вэ гэхээр Хятад улсын хилийн хязгаарын ямар ч захын боомтод аль ч улсын иргэний цахим худалдаагаар захиалсан бараа 72 цагийн дотор очиж байгаа юм. Жишээлбэл өнөөдөр Улаанбаатарт суугаа иргэн Хятадын Ивү хотоос бараа захиалахад тэр бараа илгээмж нь Эрээн хот дахь хаяг дээр 72 цагийн дотор ирж байгаа юм. Тэгээд тэр илгээмж маань наашаагаа Монгол руу орж ирэхээр хил гааль нэвтрэх гэж тэрнээсээ их хугацаа бол зарцуулж байгаа. Гэхдээ энэ мөс бол хайлж байгаа. Энэ салхи бол хагарсан. Тэмү-ийн урсгал орж ирсэн гэж түрүүн бол бид нар ярилцсан. Тэмү-ийн урсгал бол яг Хятадын цахим худалдааны 96/10 бодлогын хүрээнд 72 цагийн дотор ирээд, тэгээд ...

Ж.Золжаргал: Хятадын бодлого яах вэ, манай бодлого юу байна.

П.Цэрэнням: Тэгэхээр манайх дотооддоо болохоор ...

Ж.Золжаргал: Хятадын бодлого ярьсаар байгаад цаг чинь дуусчихлаа шүү дээ. Нэмэлт цаг өгье. 3 номер дээр.

П.Цэрэнням: Улаанбаатар хотод байгаа иргэд бол Монгол Улсын иргэдийн 70 хувь нь Улаанбаатар хотоос цахим худалдааны бараа захиалж байна. Орон нутгаас бол 30 хувь нь захиалж байна. Улаанбаатар хот дотор бол цахим худалдааны бараа хүргэлтийг бол “Юбикаб” компани, “Монгол инфинити” компани, “Пик Пак” компани гэсэн компаниуд бол хийж байгаа. Эдгээр хийж байгаа компаниудын хүргэлтийн хугацаа дээр бол бид хяналтыг хийсэн. Ер нь бол 20 цаг дотор багтааж хийж байсан. Хамгийн хурдан нь бол 2 цаг дээр энэ илгээмж хүрч

байгаа. Тэгэхээр яг практик дээр нь энэ ажлыг хариуцаж ажиллаж байгаа Юбикаб компанийн захирал Батзориг энд ирчихсэн байгаа. Тэгээд Батзориг захирлыг бас санаа оноогоо илэрхийлээсэй гэж бодож байна.

Ж.Золжаргал: Орон нутагт юм хүргэхээр зөвшөөрөл шаардлагатай гэдэг нь үнэн үү.

П.Цэрэнням: Энэ болохоор сүлжээний асуудал байгаа юм. Тэгэхээр зэрэг Юбикаб компани бол жишээ авч ярихад үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй. Улаанбаатар хот дотроо үйлчилгээ эрхлэх боломжтой гэсэн үг. Хөдөө орон нутаг руу хүрэх бол заавал сүлжээ бүхий этгээд буюу Монгол шуудан компани, Монгол инфинити компанийн шуудангийн сүлжээг ашиглаж, харилцан холболтод орж байж энэхүү илгээмж хаяглагдсан эзэндээ хүрэх ёстой юм.

Ж.Золжаргал: Сүлжээгүй компани хүргэлт хийх нь ямар эрсдэлтэй юм. Яагаад болдоггүй юм.

П.Цэрэнням: Харилцаа холболтоороо энэ илгээмж маань бол яг сүлжээ бүхий этгээдийнхээ дэд бүтцийг ашиглаж энэ илгээмж хийгддэг ийм шуудангийн зохицуулалт байгаа.

Ж.Золжаргал: Шуудангийн хуулийн зохицуулалт байгааг мэдэж байна л даа. Одоо бид нар харин хууль, эрх зүйн зохицуулалт маань юу болж байгаа билээ л гэдгийг бодоод байна шүү дээ. Боломж нь их хаягжилт хийгдээд ирэх юм бол аль болохоор л олон хүмүүст л боломжийг нь олгож нээж өгч байж л үйлчилгээгээ хүргэхгүй бол энэ улс орны чинь өнцөг булан бүрд яаж хүрэх вэ гэдэг асуудал гарч ирээд байна. Нэмэлт хариулт өгөх үү. Юбикаб гэсэн үү. Та тэр дугаартай микрофон дээр очоод ярьчих.

Мэдээж эрсдэлтэй, баталгаатай гээд сүлжээ байлгүй яах вэ. Гэхдээ нөгөө сүлжээ нь хиймэл орчин үүсгээд, тэр нь дарамт болоод тэгээд сайхан үйлчилгээ төрийн үйлчилгээг хүр хүргэдэг баатрууд болоод нөгөөхөө хийж чаддаггүй нэг ийм нөхцөлтэй болчихоод байна л даа. 1 номерын микрофон нээж өгнө үү.

Ө.Батзориг: Сайн байцгаана уу. Намайг Батзориг гэдэг. “Юбикаб экспресс”-ийн гүйцэтгэх захирал. Юбикаб, Юбикаб экспресс 2 ялгаатай компани байгаа шүү. Экспрессийн хувьд болохоор гол нь түгээлтийн горимд ажилладаг компани байгаа. Хариултын хувьд бол эхнийх болохоор бид нар сумдад бол 320 сумдад 72 цагийн дотор ямар ч барааг бид нар хүргэж өгч байгаа. гол асуудал юун дээр байна гэхээр орон нутгийн зохицуулалтын тээврийн шугамууд бол тодорхой биш байна.

2-т нь үнийн зохицуулалт бол асуудалтай байгаа.

3-д нь та бүхэн харсан байх. Тусгай зөвшөөрөлтэй компани сумуудад хүргэх ёстой гэдэг ийм асуудал яриад байна. Энэ бол бас байгаа.

4 дэх асуудал нь юу гэхээр хаягжилтын систем. Манай орон нутгийн хаягжилтын системийн сан ерөнхийдөө бүрэн бүрдээгүйгээсээ болоод хэт алслагдмал байдаг. Үүнээс болоод бид нар ерөнхийдөө хүргэлтийн горим дээр хугацаа алдах, тухайн хаягт очдоггүй, дээрээс нь олон улсын хэмжээний ийм томоохон компаниуд нэвтэрч орж ирэхэд бол хүндрэлтэй байдаг.

Тэгэхдээ бид нарын хувьд болохоор нийтдээ түрүүнд бас их зөв хэллээ. 58,2 тэрбум Тэмү-ийн барааг бол Монгол руу оруулж ирээд шиппинг хийгээд явж байна. Эндээс ойролцоогоор 18 тэрбум орчим бараа орон нутагт очсон байгаа. Орон нутгийн хэрэглэгчид болохоор юугаараа эндээс давуу талтай болж байна гэхээр хүргэлтийн төлбөр 0 хүнтэй байгаа. Бас нэмээд ярих юм бол хүргэлтийн хугацаа бол сайн байна. Бас хотоос авдаг бол та хэд мэдэх байх. Өгөөмөр, Нарантуулаас бараанд очиж байгаа. Энэ бараануудаас орон нутгийн үнэ бол 25-30 хувь өндөр байдаг. Энэ үнэ бол ерөнхийдөө бүр Нарантуулаас ч хямд үнээр тухайн орон нутгийн хэрэглэгч дээр бол очиж байгаа.

Ж.Золжаргал: Гоё мэдээлэл сонслоо. Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Анар гишүүн үг хэлэх юм уу. Пунсалмаа гишүүнээр тасаллаа. Мөнхтулга гишүүнээр. Одоо Чинбатын Анар гишүүний микрофон нээж өгнө үү.

Ч.Анар: 1 юм тодруулчихаад тэгээд үг хэлье. Энэ харилцаа холболтын гэрээ гээд байна. Энэ шуудангийн тухай хуулийн 6.1.5 дээр шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам батлах гэж байгаа. Энэ журам батлагдсан юм уу. Энэ журам батлагдсан юм уу. Энэ харилцаа холболтын гэрээ ямар журмаар гарч ирсэн юм.

Ж.Золжаргал: 1 удаа дэгийн бус зүйл хийе. 3 номерын микрофон нээж өгнө үү.

П.Цэрэнням: Шуудангийн үндсэн сүлжээний эрх олгох, хяналт тавих журам болохоор зэрэг манай яаман дээр боловсруулагдаад батлагдаад явах ийм журам байгаа. Харилцаа холболтын журам болохоор Харилцаа холбооны зохицуулах хороо дээр явдаг ийм журам байгаа. Журам бол өнөөдөр хэрэгжээд явж байгаа.

Монгол шуудан компанийн захирал Хосбаяр түрүүн хэлсэн. Бид нар 14 аж ахуйн нэгжтэй харилцаа холбоотой явж байна гэж хэлсэн. Хэрэгжээд явж байгаа.

Ж.Золжаргал: Ундрам гишүүний микрофон нээж өгнө үү. Бид нар шуудангийн асуудлыг ер нь ярих цаг нь болсон. Ер нь оройтчихсон байна. Тийм учраас бид нар энэ салбар дээр Байнгын хорооны хувьд анхаарал тавих нь зүйтэй. Сая би бас харлаа л даа. Хамгийн сонгодог шуудангийн жишээ гээд Роял Мэйл гээд Английн шуудан байдаг 500 гаруй жилийн түүхтэй. Энэ компани бол 2011 онд шуудангийн үйлчилгээний хуулиа шинэчлээд, тэгээд 2013 оноос хувьчлаад, 2015 онд үлдсэн хувьцаагаа хувьчлаад 100 хувь олон нийтийн компани болчихсон юм байна. 499 дэх жил дээрээ. Тэгээд одоо ашигтай ажилладаг. Улсад татвар төлдөг ийм компани болчихсон байдаг юм байна.

Бас нэг сонгодог жишээ Японы Нипон Юби юм билүү тийм компани байдаг. Энэ бас л хууль гараад олон нийтийн компани болоод, тэгээд одоо ашигтай. Тэгээд үргэлжлүүлээд энэ шуудангийн байгууллагууд нь бас банкны үйл ажиллагаа давхар эрхэлдэг болчихсон юм байна. Тэгээд ингээд улам томроод, бүх жижиг засаг захиргааны нэгжүүдэд хүрээд ажиллаад явж байгаа ийм жишээнүүд байна.

Тэгэхээр бид нар мэдээж гаднын сайн туршлагуудыг судлаад өөрийнхөө улс орны онцлогт тохируулаад, тэгээд энэ салбарыг шинэчлэх цаг нь болсон байна

гэж үзэж байна. Хэрвээ бид нар хувьчилчих юм бол олон нийтийн компани болгочих юм бол магадгүй энэ хаягжилтыг чинь энэ компаниуд нь өөрсдөө хийгээд өгөх юм шиг байна. Энэ хаягжилттай холбоотой ажлын хэсэг 2021 онд байгуулагдсан байхгүй юу. Барилга, хот байгуулалтын яам дээр. Тэгээд өнөөдрийг хүртэл ерөөсөө үүнтэй холбоотой ажил 1 ч хийгдээгүй, бүр орхигдоод, хүмүүс нь зугтаад энэ ажлаасаа төвөгтэй учраас. Тэгээд Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө орж ирэхээр би асууж байсан. Тэгэхэд бас л 2 яам нь мэдэхгүй, хотын захиргаа болохоор бид нар удахгүй хийчихнэ гэсэн ийм ерөнхий юм яриад, тэгээд хаяж байгаа юм.

Тэгэхээр ер нь бол энэ салбар цаашид олон нийтийнх болж, илүү либералчлагдаж, ингэж явах нь зүйтэй гэдэг нь энд явагдаж байгаа асуулт хариултаас ч гэсэн харагдаж байна. Тэгэхээр энэ чиглэл рүү л ер нь ажиллах ёстой гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Пунсалмаа гишүүн үг хэлнэ.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Дэлхий нийтээрээ ер нь тэгээд онлайнаар бараа таваараа захиалаад, хүргүүлээд үндсэндээ сурчихлаа. Үүнийг дагаад энэ үндэстэн дамнасан тээвэр логистикийн асар том зах зээл бий болчихлоо. Тэгээд Монгол Улс бол геополитикийн хувьд хамгийн зөв байрлалтай буюу Евразийг холбосон хамгийн дөт зам дээр бид нар зогсож байгаа. Энэ утгаараа бид нар Азиас гарч байгаа энэ их бараа бүтээгдэхүүнийг Европ руу дамжуулан ачих логистик болж хөгжих боломжтой. Тэгэхээр өнөөдөр энэ эрх, үүргийг хуулиараа хэрэгжүүлж болох хамгийн боломжит компани бол Монгол Шуудан компани байгаад байгаа.

Тэгэхээр өнөөдөр Монгол шуудан компани хуулиараа боломжтой ч гэсэн өнөөдөр энэ менежмент, өнөөдөр цаг хугацаатай уралдаж байгаа энэ олон улсын стандарт шаардлагад хүрч чадахгүй байна. Яагаад гэхээр энэ компанийн 34 хувь нь хувийн компаниуд байдаг. Хувьцаат компанийн 66 хувь нь төрийн компани байгаа. Төрийн энэ том бүтэц чинь хөдөлж өгөхгүй. Хувийн компаниуд хөрөнгө оруулалт хийе гэвч энэ 66 хувь хөдлөхгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ хувьцаат компанийн эрх зүйн орчныг нь 1 тийш нь болгох хэрэгтэй. Давуу эрхтэй хувьцааг нь эсвэл төрийн өмчийн компани руу шууд шилжүүл, эсвэл хувийн компани нь давуу эрхтэй хувьцаагаа эзэмшээд энэ логистик хаб хийх менежментийг маш яаралтай сайжруулах хэрэгтэй. Ингэж байж бид нар Ази Европыг холбосон энэ логистик төв энэ тээвэр логистикийг Монгол Улс барьж авах ёстой. Эс бөгөөс бид нар энэ тээвэр логистикийг хийж гүйцэтгэх хувийн компаниудыг ажиллах эрх зүйн орчныг сайжруулах ийм шаардлагатай момент дээр иржээ. Цаг хугацаа бол байнга бид нартай уралдаж байгаа. Өнөөдөр бид нарын өрсөлдөгч улс орнууд Казахстан байна. Турк байна. Евразийг холбосон энэ бүс нутгууд байна. Бид нар бол бүс нутгийн хувьд хамгийн ойрхон байгаад байдаг. Гэтэл энэ бодлогоороо ингээд хоцроод байж болохгүй байна. Энийг бид нар яаралтай шийдвэрлэж, хууль, эрх зүйн орчныг сайжруулах ёстой гэж үзэж байгаа шүү.

Ж.Золжаргал: Баярлалаа. Цэнгүүн гишүүн үг хэлнэ.

С.Цэнгүүн: Шуудангийн салбарын одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудыг шинэчлэхтэй холбоотой бас саналаа хэлэх гэсэн юм. Бид нар ер нь хууль тогтоомжуудыг шинэчилнэ гэхээр хуулиудыг чангатгах, эсвэл ард иргэд дээр илүү олон зөвшөөрөл, ямар нэгэн журмуудыг батлаад, үйл ажиллагааг нь урьд нь

хуульгүйгээрээ болоод байсан үйл ажиллагааг илүү хүндрүүлчихсэн болгодог ийм тал ажиглагдаад байдаг манай хуулиудаас. Тэгэхээр энэ хуулийг шинэчилж гаргахдаа цахим худалдаанд хүргэлтийн үйлчилгээ үзүүлж байгаа энгийн иргэд маань одоо хийж байгаа үйл ажиллагаа ямар нэгэн хууль зөрчигч бишээр, энгийнээр бүх хүн оролцох боломжтой тийм хууль, эрх зүйн орчныг нь бид нар бүрдүүлэх дээр анхаарах ёстой. Тэгэхээр энэ шуудангийн хүргэлтийн тухай хуулийн үзэл баримтлал нь өөрөө зах зээлийн эдийн засагт тулгуурласан чөлөөт өрсөлдөөнийг дэмжсэн ийм үзэл баримтлалтай шинэчлэл болоосой гэж хүсэж байна. Тэгэхээр нэлээн том өөрчлөлтийг бид нар бас хийх зайлшгүй шаардлагатай юм байна гэж харагдаж байна.

Ж.Золжаргал: Үг хэллээ. Мөнхтулга гишүүн үг хэлнэ.

П.Мөнхтулга: Энэ асуудлыг Байнгын хорооны даргад миний бие уламжлаад, тэгээд өнөөдрийн хэлэлцүүлэг болж байгаа юм: Би цахим байнгын хороонд байдаггүй. Тэгэхдээ гишүүнийхээ бүрэн эрхийн хувьд үг хэлж байгаа юм.

Гол 2 шалтгаан байгаа. 1 нь үндэсний хэмжээнд бид нар и-коммерс буюу цахим худалдаагаа зах зээлийг нь 2 дахин тэлэх, бид нар эдийн засгийн жижиг бараа бүтээгдэхүүний урсгалыг 2 дахин нэмэх боломж харагдаж байгаа. Үүнийг бол зөвхөн Монгол шуудан компани л хийнэ. Одоо бол яг ард түмний нуруун дээр бизнес эрхлэгчдийн өөрсдийнх нь хүргэлтээр, дайвар ачаагаар, замын унаагаар 19 дүгээр зууны үедээ байгаа. Бараг 1 машин, тээврийн хэрэгсэл нь л солигдсон болохоос биш жин тээж байгаатай адилхан хүнд дайгаад л явуулдаг. Тэгэхээр 21 дүгээр зууны цахим Монгол шилжилт энэ тэр чинь хаачсан юм бэ. Бид нар одоо яг энэ 19 дүгээр зуундаа байгаад байх юм уу. Хөдөөгийн иргэд цахим худалдаанд орж чадахгүй байгаа. Мэдээллийн найдвартай эх сурвалжаас мэдээ авч чадахгүй байгаа. Фэйсбүүкийн хов жив, найдваргүй эх сурвалж, эгөө троллуудын мэдээгээр л явж байгаа.

Тэгэхээр шуудангийн салбар гэдэг бол онц байдал зарласан үед, ямар нэгэн мэдээллийн цахим урсгал хаагдсан дайны байдлын үед манай стратегийн салбар. Тэгээд энийгээ бид нар ингээд хайхрамжгүй хаячхаж болохгүй. Тэгэхээр энэ дээр дутагдаж байгаа эрх зүйн бодлогын дэмжлэгүүдийг үзүүлнэ. Харин тэр хувь хувьцааг нь авсан хувийн хэвшлүүд маань энэ дээр маш тодорхой саналуудаа өгөх ёстой. Тэгээд хамтраад явъя гэж байгаа юм.

Ингэснээрээ тал бүрийн ашигтай. Хөдөөгийн иргэд маань цахим худалдаанд оролцоно. Бизнес эрхлэгчид маань и-коммерсын 50 хувийн боломж нээгдэнэ. Хүн амын тал хувь нь хотод байна. Тал хувь нь хөдөө орон нутагт л байна шүү дээ. Тэгэхээр энэ боломжуудыг нээж өгөх юм. Найдвартай мэдээллийн эх сурвалжтай болно. Бид нар өдөр тутмын сонин гэж байдаг байсан. Одоо сонины эх үүсвэр, эх сурвалж тоогдохоо байлаа. Яагаад вэ гэхээр энэ худал хуурмаг мэдээ факт чек гэсэн юм байхгүй. Зүгээр энэ сошиалын олноос олон руу түрэмгийлж байгаа гүтгэлэг дунд иргэд мэдээлэл авдаг болсон. Үүнийг баттай эх сурвалж нь бол өдөр тутмын сонины редакцууд мэргэжлийн сэтгүүл зүй байсан. Тэгэхээр энийг түгээдэг үндсэн логистик, үндсэн дэд бүтэц нь бол Монгол шуудан компани байсан.

Тэгээд ингээд хувьчлагдахлаараа энэ үндэсний стратегийн чиг үүргээ биелүүлэхээ больчихдог юм уу, эсвэл ямар асуудал байгаа юм. Тэрийгээ маш тодорхой хэлэх, саналаа хүргүүлэх хэрэгтэй байна. Тэгэхээр улс л юм бол бид нар

19 дүгээр зуундаа хэвлэл мэдээлэл нь албан ёсны эх сурвалж нь нийт хүн амынхаа талд нь хүрдэггүй, нийт хүн амынх нь тал нь 19 дүгээр зуундаа гацдаг ийм байдалтай байж болохгүй.

Тэгэхээр Монгол шуудан компани одоо яаралтай реформоо хийх ёстой. Тэгээд энэ үүднээс Цахим хөгжлийн байнгын хороонд хувь гишүүнийхээ зүгээс санал оруулж, өнөөдрийн асуудлыг хэлэлцүүлж байгаа юм. Тэгэхээр та бүхнээс одоо ажлын хэсэг байгуулагдах байх. Ажлын хэсэгт би оролцоод явна. Орон нутгийн гишүүд оролцоод явна. Тэгээд дэд ажлын хэсгүүдэд салбараас төлөөлж оролцоод хамтдаа асуудлаа шийдээд ард нь гаръя гэж ийм уриалга дэвшүүлж байгаа юм. Баярлалаа.

Ж.Золжаргал: Анар гишүүн үг хэлнэ. Микрофон нээж өгнө үү.

Ч.Анар: Миний харж байгаагаар бол гол асуудал нь энэ хууль маань зайлшгүй шинэчлэн найруулагдах шаардлагатай болчихжээ. Цаг үе, нийгэм, эдийн засгийн хөгжилтэйгөө нийцэхгүй байна. Тэгэхээр энэ хуулиа шинэчлэн найруулах нь Их Хурал, Байнгын хороо бид нарын үүрэг байна л гэж харж байна л даа. Тэгэхээр нөгөө хариуцсан яамтайгаа хамтарч ажиллаад, дараа жил гэлтгүйгээр хэдүүлээ хамтарсан байдлаар энийг яаралтайгаар орж ирэхгүй бол эдийн засгийн хувьд бол бид нар Евразийн хэдэн том боломжоос хоцорч байна.

2 дугаарт тэр нийтийн үүргээ хэрэгжүүлж чадахгүй байна. Орон нутгийн иргэдэд бараа, шуудан захиа, сонин хэвлэлээ захиж чадахгүй байна. Энэ ажлын хэсэг дээр бол Монгол шуудан компанийн ярьж байгаа асуудлуудыг бас нухацтай бодох хэрэгтэй. Хэдэн хувь, ер нь засаглал менежментийг яаж сайжруулах юм. Хэдэн хувь нь төрийн нийтийн үүргээ хүлээх ёстой гээд саналуудыг оруулаад энэ дээр ерөнхийдөө Байнгын хороо яамтайгаа хамтраад энэ хуулийн шинэчлэлийг бол хурдан оруулах нь зүйтэй юм байна л гэсэн саналтай байна.

Ж.Золжаргал: Баярлалаа. Ингээд дараагийн асуудал дээр бол ажлын хэсэг байгуулна. Тэгэхдээ түүнээс өмнө нэмэлт мэдээлэл авах 2 хүн байгаа. Тэгээд та бүхний мэдээллийг сонсчхоод 1 дүгээр хэсгээ хаая. Зөвлөх инженер Баатархүү. Энэ салбарт их олон жил ажилласан хүний хувьд та 4 минутад багтаагаад цагаа бариарай. 4 минутдаа багтаагаад асуудал шийдэл талаар бодлоо илэрхийлнэ. Дараа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Цэнгэл. Монгол шуудан компанийн төрийн үйлчилгээ, төрийн үйлчилгээг хүргэж байгаа төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд үйл ажиллагаа дээр ямар үнэлэлт дүгнэлт өгч байгаа вэ гэсэн ийм мэдээлэл өгнө үү. 1 номерын микрофон нээж өгье.

Ж.Баатархүү: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Би уг нь мэдээлэл хийе гэхээр хэдхэн слайд бэлдээд явуулчихсан. Тэгээд тэр маань ирээгүй юм шиг байна. Ер нь бол шуудангийн өнөөдрийн ярьж байгаа асуудлыг бол би маш сайн ойлгож байна. Ер нь 1990 он хүртэл шуудан, цахилгаан холбоо 2 бол ерөөсөө хамтдаа харилцаа холбооны салбар гэж ингэж явсан. Тэгээд 1990 он гараад шатахууны хомсдолоос үүдээд яг шуудангийн хот хооронд болон хотын шуудан тээвэр хүргэлт 100 хувь яг тээврийн хэрэгслээс шалтгаалсан үед бол шууданд маш их хүндрэл үүссэн. Тухайлах юм бол 1990 оноос эхэлж давтамж нь буурсаар байгаад, тэгээд 1992 онд аймаг сум хооронд 7 хоногт 3 удаа шуудан хүргэдэг байсан онгоц бүрэн зогссон.

Улаанбаатар хотын төвийн шуудан хүргэлтийг хариуцдаг байсан шуудангийн 2 дугаар бааз бол яг цагтаа бол үйлчилгээнд гарах боломжгүй болсон. Дээрээс нь нэмээд сумаас цаашаа шууданг хүргэдэг байсан УАЗ-452 машиныг аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлснээр сумаас цаашаагаа шуудан бол явгарсан юм. Тэгээд шууданд бол маш их хүндрэл учирсан.

Дээрээс нь цаасны хомсдолоос болоод түрүүний ярьдаг тэр шуудангийн ашиглалт үйлчилгээний гол бүтээгдэхүүн байсан хэвлэл захиалга бол хэвлэл тогтмол хэвлэл бол гарахаа байсан. Үүнээс болоод шууданчдын ажлын байр чинь ажилгүйдэл үүсэж, шууданчид бүр ажилгүйдэлд өртөх ийм эрсдэл хүртэл үүсэж байсан. Тэгээд энэ үед бол яах вэ, гэхээр нөгөө хамт явж байсан учир яг шуудангийн алдагдал зардал нь юу юм, цахилгаан холбооных нь юу юм гэдгийг ялгаж салгаж тогтоолгохын тулд 1990 онд Цахилгаан шуудан холбооны газрыг салгаад Шуудан холбооны газар, Цахилгаан холбооны газар гэж 2 тусад нь байгуулсан юм. Ингэж явж байгаад тэгээд цаашдаа яасан бэ гэхээр зэрэг яг тухайн үед нөгөө талаас манай цахилгаан холбооны чинь нөгөө аналог технологи чинь хуучраад тоон технологид шилжих шилжилт хийх хэрэгтэй болсон. Тэгээд энэ Засгийн газрын шийдвэр бодлого гараад, ер нь бол энэ цахилгаан холбоонд хийх шинэчлэлийг Азийн хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл авч, тэр хөрөнгө оруулалтаар хийх нь зүйтэй юм байна.

Ийм учраас цахилгаан холбоог цаашид нь зээлээ төлөх мөн ашигтай ажиллуулж, улсын төсөв бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр нь хөгжүүлье. Харин хөдөө, орон нутаг болоод төрөөс нийгэмд үзүүлдэг энэ үйлчилгээг шууданд хариуцуулаад, Монгол шуудан компани нэртэй улсын үйлдвэрийн газар байгуулах нь зүйтэй гээд салгасан ийм учиртай юм.

Тэгээд тэрнээс эхэлж яг шуудан бол дангаараа төрөөс нийгэмд үзүүлэх үйлчилгээг хариуцах ийм чиг үүрэгтэй ажиллаж ирсэн юм. Тэгээд тэрнээс гарах алдагдал энэ тэрийг бол төсвөөс хариуцна энэ тэр гэж байсан. Тэгээд цахилгаан холбоо компанийнхаа орлогоос бид нар нөхдөг байсан чинь нөгөөдөх маань ашгийн чиглэлээр хувьцаат компани болоод явсан чинь нөгөө алдагдлыг нөхөх газаргүй болоод ирсэн. Тэгээд 1994 онд Дэд бүтцийн хөгжлийн яам байгуулагдсанаар ер нь энэ шууданг яах вэ гээд тэр дээр бол шуудангийн чиг үүргийн 2 компани байсан. Монгол шуудан, Монгол Марк компани. Энэ 1 чиг үүргийн 2 компанийг нэгтгэе. Нэгтгэснээрээ зардлуудын давхардлыг арилгая. Орлогын эх үүсвэрүүдийг нь нэгтгэе гээд 1997 онд энэ 2 компанийг нэгтгэж байгуулаад, ингэснээр бол ерөөсөө 1997 оны жилийн эцсээр гэхэд шуудан компани 300 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөн байсан компани маань 5 сая төгрөгийн ашигтай ажилласан байхгүй юу. Ингээд 2001 он гэхэд бол ашиг нь өсөөд, бүр 9 аймгийн шуудан холбооны газар алдагдлаас гарч байсан ийм сэргэлт болж байсан.

Тэгээд 2001 оноос эхлээд шуудангийн эрх зүйн орчныг бүрдүүлье гээд шуудангийн бие даасан хууль гарсан. 2004 он одоо бол .../минут дуусав/

Ж.Золжаргал: Баатархүү инженер нэмэлт 1 минут өгье. Та 1 минутад багтаагаад дүгнэлтээ хэлээрэй.

Ж.Баатархүү: Шуудангийн гол нь тэр байрны асуудал яригдсан юм. Энэ тэр 1994 онд анх эхлээд цахилгаан, шуудан холбоо 2-ыг салгахдаа шуудангийн

ашиглалт үйлчилгээний зориулалтын байр талбайг шууданд нь шилжүүлэхээр ийм шийдвэр гарсан юм. Тэгэхдээ тухайн үедээ бас шуудан ашиглалтын зардлыг нь хариуцаж чадахгүй гэдгээр шилжүүлж аваагүй.

Тэгэхдээ энийг шуудангийн өнөөдрийн үндсэн сүлжээ эзэмшигчийн дансанд шилжүүлэхийн тулд Төрийн өмчийн хорооны тогтоол Улаанбаатар хотын шуудангийн салбаруудыг шилжүүлэхийнх нь Төрийн өмчийн хорооны тогтоол 1998 онд гарсан. Их хурлын тогтоол 2003 онд гарсан. Хамгийн сүүлд нь Засгийн газрын тогтоол 2006 онд явсан. Энэ тогтоолуудаар бол шуудангийн зориулалтын байр талбай бол Монгол шуудан компанийн баланст шилжсэн байх ёстой. Тэгээд 2003 оноос шуудангийн зохицуулалт жинхэнэ ёсоор хэрэгжиж эхэлсэн. Тэгэхдээ бол тусгай зөвшөөрлийг олгох, түрүүн яриад байна лээ. Тэр ингээд либералчлал .../минут дуусав/

Ж.Золжаргал: Баатархүү инженерт баярлалаа. Ажлын хэсэг байгуулагдахаар та боломж байвал хамтарч ажиллаарай. Ингээд Цэнгэл дарга. Монгол шуудан компанийн үйл ажиллагаанд ямар үнэлэлт дүгнэлт өгч байгаа талаар мэдээлэл өгнө үү. 1 дүгээр микрофон нээж өгье

Б.Цэнгэл: Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол шуудан компани үүргээ биелүүлж байна уу, үгүй юу гэж асууж байна. Би бол үүргээ сайн биелүүлж байгаа гэж би хэлмээр байна. Яагаад ингэж хэлж байгаа гэхээр энд бол маш их олон шалтгааныг дурдаж болно л доо.

Сая Монгол шуудан компанийн дэд захирлын танилцуулга дээр бол гарлаа шүү дээ. Тулгамдаж байгаа асуудлууд гээд энэ дээр бол манай Их Хурлын гишүүд бас анхаарлаа хандуулсан байх гэж бодож байгаа. Тэгэхээр хамгийн түрүүнд бодлогын баримт бичиг үгүйлэгдэж байна. 1 дүгээрт.

2 дугаарт эрх зүйн орчин буюу хуулийг зайлшгүй эргэж харах бодит шаардлага бол байна уу гэвэл байгаад байгаа юм. Тэгэхээр энэ юмнуудаа хийж байж, өөрөөр хэлбэл Монгол шуудан компани бол 1 ёсондоо бол яг 2 юмны уулзвар дээр голд нь ирчихсэн. Хөрөнгө оруулалтаа шийдэж чадахгүй яг төрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах уу эсвэл хувь талдаа дэмжээд явах уу гэдэг юмны яг голд яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нь өөрөө бол эрх зүйн зохицуулалт нь сул байгаагийн 1 илрэл. Тэгэхээр манай Их Хурлын гишүүд бол энийг бас яг зөв олж харсан байна. Тийм учраас одоо бол энэ хуулийг эргэж хараад, харин зүгээр яаж бүгдээрээ энийг зөв хийх вэ гэдэг асуудал дээр л төвлөрч ажилламаар байгаа юм. Яаж зөв хийх вэ гэдэг асуудлыг би юу гэж хэлэх гээд байна гэхээр энэ бол зүгээр нэг тийм жирийн компани биш юм байгаа юм л даа. Тухайлбал НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох Дэлхийн шуудангийн байгууллагаас Монгол Улсын Засгийн газар үүрэг хүлээчихсэн. Тийм ээ. Үндэсний операторыг байгуулах гэрээ. Энэ дээр бол алслагдсан орон нутагт үйлчилгээг маш хөнгөлөлттэй тарифаар хүргэх ийм үүрэгтэй байгаа шүү дээ. Тэгэхээр ерөнхийдөө бол хэрэв магадгүй зүгээр одоо бол 66 хувь нь төрд байгаа, 34 хувь нь бол иргэд, аж ахуйн нэгжид байж байгаа. Энийг тухайлбал харьцааг нь өөрчилж болно. Энэ бол бүрэн нээлттэй асуудал.

Бид нар бол Монгол шуудан компанийг IPO гаргах жагсаалтад Их Хурлын үндсэн чиглэлд нь оруулах асуудлыг хөндөж ярьж байсан. Тэгээд бид бол яах вэ нээлттэй хувьцаат компани гэж үзээд, энэ асуудлаас хасаж байсан юм. Ер нь бол

зүгээр ямар санал гардаг вэ гэхээр бол манай 34 хувийг эзэмшиж байгаа Ард санхүүгийн нэгдэл, Барсын Амараа гээд нөхөр байдаг юм шиг байгаа юм. Тэгээд бас 3 мянга гаруй иргэд байгаа шүү дээ. Тэр хүмүүсээс юу гэж санал тавьдаг гэхээр бол ерөөсөө энийг цааш нь хөрөнгө оруулалтыг авч явахад болохгүй байна. Тийм учраас 34 хувийг эргэж хармаар байна. Бид хувиа өсгөж байж хөрөнгө оруулалтын тухай ярих ёстой гэдэг ийм саналыг бол байнга тавьдаг л даа.

Тэгэхээр энийг хууль, эрх зүйн орчинд нь Их Хурал, Засгийн газар жагсаалтаа оруулаад, Их Хурал үндсэн чиглэлийг баталж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүрээндээ магадгүй 2025-2028 он гэх юм уу IPO гаргах, төрийн өмчит компаниудын менежментийг сайжруулах үндсэн чиглэлийг батлах явцад Монгол Шуудан компанийн энэ одоо 34 хувийг хөндөх асуудлыг бол оруулж ирж болох юм. Энэ бол нээлттэй.

Тэгэхийн тулд бид энэ дээр бол нэлээн судалгаа хийж, Их Хурал, яамтайгаа манайх сайн хамтарч л ажиллах л ийм зайлшгүй шаардлага гарч байгаа юм л гэж ойлгож байгаа.

Ундрaм гишүүн бол бас сайн туршлага бусад орны сайн туршлагыг ярьж байна. Английн туршлага ярьж байна. Гэхдээ бас тааруу туршлагууд ч бас байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл тухайлбал зарим оронд бол ер нь энэ шуудангийн үйлчилгээг төр бүр төсөвтөө аваад явдаг ч ийм хувилбарууд байж байгаа. Тийм учраас энийг бол нэг ёсондоо үүрэг .../минут дуусав/

Ж.Золжаргал: Цэнгэл даргад баярлалаа. Бас дээрээс нь сайхан дүгнэлт хэлээд өгчихлөө. Ер нь 3,5 сая хүн 1,5 сая хавтгай дөрвөлжин километр нутагт байгаа. Тэгээд ингэж тархаж суурьшсан үндэстэн мэдээж шуудан хамгийн чухал нь ойлгомжтой. Тэгэхээр стратеги байх ёстой юу гэвэл байх л ёстой. Ямар ч тохиолдолд ажилладаг сүлжээ Монгол Улсад байх шаардлагатай нь бол үнэн.

Тэгээд өнгөрсөн хугацаанд ямар ч байсан тэр нийгэмд шилжээд хэцүү хүнд үе өнгөрөөд Монгол Шуудан компани бол үүргээ гүйцэтгэсэн гэж их тэмдэглэж байна. Тэр дээр нь бас би хувьдаа бол тодорхой хэмжээнд санал нийлж байгаа. Энэ ажлаа бол хийж ирсэн. Одоо цаг үе маань өөр болчихсон байна. Их олон тоглогч нар гараад ирчихсэн байна. Цахим худалдааны маш том орон зай бий болчихсон байна. Тийм болохоор эрх зүйн орчиндоо зохицуулалт хийж стратегиа барина. Гэхдээ нээлттэй олон тоглогчдыг оруулж энэ салбар өөрөө төрөөс төсөв дээр ачаа болдог биш, мөнгө олдог ийм амьд салбар болох цаг үе нь болжээ гэж. Энэ зорилгоор бол өнөөдөр ингээд бид байр сууриа сонсож, асуултад хариуллаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

15.46 цаг.

Хэлэлцэх асуудал 2. **Байнгын хорооны тогтоолын төсөл танилцуулна.**

Шуудангийн хүртээмжийн асуудал маань улс орны өнцөг булан бүрд хүрэх шаардлагатай учраас тойргийн гишүүдээс энэхүү ажлын хэсэгт орох хүсэлтээ ирүүлсэн байгаа. Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан. Ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Мөнхтулга, Идэрбат, Сэддорж, Заяабал гэсэн Инновац, цахим бодлогын байнгын хорооны бус Улсын Их Хурлын гишүүд оролцохоор нэрсээ ирүүлсэн байна.

Тогтоолын төслийг уншиж танилцуулна.

Ажлын хэсгийн ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн дугаар заалтуудын дагуу Инновац, цахим бодлогын байнгын хорооноос тогтоох нь.

“Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагаа, үндэсний хэмжээний шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтын талаар мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан Шуудангийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн журмын биелэлтийг хянан шалгах, шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтыг сайжруулах, цахим худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх талаар санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнхбат Улсын Их Хурлын гишүүн, гишүүд Ч.Ундрэм, Б.Заяабал, Ч.Анар, Р.Сэддорж, Ц.Идэрбат, П.Мөнхтулга, Б.Пунсалмаа.

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллага салбарын мэргэшсэн шинжээчдийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг Ц.Мөнхбатад зөвшөөрсүгэй гэсэн ийм агуулгатай тогтоол байна.

Байнгын хорооны тогтоолтой холбоотой асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Анар гишүүн дарсан уу. Ундрэм гишүүн үг хэлж, асуулт асууна.

Ч.Ундрэм: Ажлын хэсэг байгуулах асуудлыг бол дэмжиж байгаа. Зүгээр энэ нөгөө гол ажлын хэсгийн зорилго дотроо бүр Шуудангийн тухай хуулийг шинэчлэх ч байдаг юм уу, хууль, эрх зүйн орчныг нь шинэчлэх гээд оруулчхаж болдоггүй юм уу. Одоо бид нар чинь энэ дээр ажиллаад энэ хуулиудын хэрэгжилтэд нарыг шалгаад, тэгээд баахан ажиллаж ажиллаж байгаад Байнгын хорооны ганц тогтоолтой л болох гээд байна л даа. Тэгэхээр бүр шууд хууль, эрх зүйн орчныг сайжруулах ийм зорилгоор байгуулагдчих юм бол салбарын яамтайгаа болон бусад байгууллагуудтайгаа хамтраад бүр хуулиа шинэчлэх ийм ажил дээр ажиллаад эхэлбэл бүр хурдтай, тэгээд дорвитой өөрчлөлт хийх юм биш үү гэдэг ийм л асуулт гэх юм уу, санал байна.

Ж.Золжаргал: Цэнгүүн гишүүн үг хэлэх юм уу. Гар өргөсөн үү, үгүй юу. Тэгэхээр ямар хуулийн төсөл гэсэн үг вэ. Шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл гэхсэн байгаа шүү дээ. Тэр дээрээ шаардлагатай бол Шуудангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга гэх үү.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Тогтоолын төслийг уншиж өгөөд, санал хураая. Бүхлээр нь унших уу.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Нэг.“Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагаа үндэсний хэмжээний шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтын талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан Шуудангийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон бүх нийтийн үйлчилгээний үүрийн сангийн журмын биелэлтийг хянан шалгах, шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтыг сайжруулах, цахим худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх талаар санал дүгнэлт гаргах эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнхбат, гишүүд Ч.Ундрэм, Ч.Анар, С.Цэнгүүн, Б.Заяабал, Р.Сэддорж, Ц.Идэрбат, П.Мөнхтулга, Б.Пунсалмаа.

Хоёр.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллага, салбарын мэргэшсэн шинжээчдийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг Ц.Мөнхбатад зөвшөөрсүгэй.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Пунсалмаа гишүүн микрофон нээж өгье.

Б.Пунсалмаа: Горимын санал гаргая. Төхөөрөмж ажилласангүй миний. Санал хураалтыг хүчингүй болгоод, дахиад санал хураах саналыг оруулж байна.

Ж.Золжаргал: Пунсалмаа гишүүний гаргасан горимын саналын дагуу төхөөрөмж гацсан тул санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт дэмжигдсэнгүй. Цэнгүүн гишүүн горимын санал гаргана.

С.Цэнгүүн: Горимын санал гаргах гэсэн юм. Сая төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгоод, санал хураалтыг гар өргөж явуулахыг хүсье.

Ж.Золжаргал: Цэнгүүн гишүүний гаргасан горимын саналын дагуу Пунсалмаа гишүүний гаргасан горимын саналын санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт. Төхөөрөмж болохгүй байна. Анар гишүүн горимын санал.

Ч.Анар: Төхөөрөмж ажиллахгүй байгаа тул энэ санал хураалтыг хүчингүй болгож, гараар санал хураалт явуулах горимын санал гаргаж байна.

Ж.Золжаргал: Цэнгүүн гишүүний гаргасан горимын саналын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг хүчингүй болгох саналыг гар өргөж хураана. Байнгын хорооны гишүүдийн ирцэд орсон 9 гишүүнээс 6 нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Одоо Пунсалмаа гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгох гэсэн томъёоллоор хүчингүй болгохыг дэмжье гэсэн томъёоллоор гар өргөж санал хураана. Санал хураалт. 9 гишүүнээс 6 нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Одоо байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор гар өргөж санал хураана. Санал хураалт 9 гишүүнээс 6 нь дэмжиж, тогтоол батлагдлаа.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

16.00 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ